

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-3

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 4-31

---

<i>1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	5
<i>2. “Ажлын хэсэг тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол хэл, бичгийн үнэлэмж, хэрэглээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	5-6
<i>3.Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын талаарх Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох</i>	6-31

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
10 дугаар сарын 18-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Б.Жаргалмаа;

Чөлөөтэй: П.Анужин, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг, Ж.Чинбүрэн;

Тасалсан: С.Чинзориг.

Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг хэлэлцэх асуудлын дарааллын хоёр, гуравдугаарт орсон асуудлуудыг хэлэлцэх асуудлын дарааллын нэг, хоёрдугаарт оруулж хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 0

Бүгд: 9

100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Мөнхцэцэг:** “Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 0  
Бүгд: 9  
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 13 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.*

**Хоёр.** *“Ажлын хэсэг тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол хэл, бичгийн үнэлэмж, хэрэглээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/*

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Л.Энх-Амгалан нар санал хэлэв.

**Г.Мөнхцэцэг:** “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 0  
Бүгд: 9  
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 13 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** *Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын талаарх Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны сайдын Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөх П.Оюунаа, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн яамны Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Х.Тамир, Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга А.Халиунаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нансалмаа, Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга Ш.Алтангэрэл, Захиалагчийн хэлтсийн дарга Н.Амарбаяр, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал М.Итгэл, Боловсролын үнэлгээний төвийн захирал Л.Ганбат, Боловсролын ерөнхий газрын Ариун цэврийн байгууламж төслийн зөвлөх Г.Цэрмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Ц.Мөнхцэцэг, Б.Баярсайхан, Г.Дамдинням, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын талаарх Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонслоо.

*Уг асуудлыг 14 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 34 минут үргэлжилж, 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр 14 цаг 53 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
БОЛОВСРОЛ, СОЁЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 10 дугаар сарын 18-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
13 цаг 19 минут.

### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Мөнхцэцэг:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан ирц бүрдсэн тул хуралдааныг эхэлье. Хуралдаанд ирцийн мэдээ танилцуулдаг, ирцийн мэдээг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн ирсэн байна. Амгалангийн Адъяасүрэн гишүүн Баянхонгор аймаг 3 дугаар тойрог гадаадад томилолттой байна. Пүрэв-Очирын Анужин гишүүн 28 дугаар тойрог СХД чөлөөтэй байгаа юм байна. Тилеуханы Аубакир гишүүн Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог ирсэн байна. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг Архангай аймаг 1 дүгээр тойрог чөлөөтэй байна. Балжиннямын Баярсайхан Завхан аймаг 9 дүгээр тойрог ирсэн байна. Энхбаярын Батшугар СХД 28 дугаар тойрог ирсэн байна. Хассуурийн Ганхуяг БГД 26 дугаар тойрог чөлөөтэй байна. Гонгорын Дамдинням Дархан-Уул аймаг 19 дүгээр тойрог ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа СХД 27 дугаар тойрог гадаад томилолттой байгаа юм байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн СБД 24 дүгээр тойрог ирсэн байна. Чинбатын Ундрэм Сэлэнгэ аймаг 13 дугаар тойрог ирсэн байна. Ням-Осорын Учрал СХД 28 дугаар тойрог ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн БЗД 23 дугаар тойрог чөлөөтэй байна. Содномын Чинзориг гишүүн Өвөрхангай аймаг 10 дугаар тойрог одоогоор алга байна. Лувсаньямын, Лувсанцэрэнгийн

Энх-Амгалан гишүүн Хөвсгөл аймаг 17 дугаар тойрог ирсэн байна. Ингээд 9 гишүүн ирсэн учраас ирц бүрджээ.

Хуралдаанаа эхэлье. Хуралдаанд хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. 1 дүгээрт Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалт сэдвээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсоно. 2 дугаарт Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батална. 3 дугаарт намрын чуулганы 10 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тогтоолын төслийг батална.

Хэлэлцэх асуудлын дараалал өөрчлөх горимын санал гарах байгаа. 1 болон 3 дугаар асуудлын дарааллыг өөрчлөх горимын санал хураалтыг явуулъя гэсэн ийм санал хураалтыг явуулъя. Тийм, ирцтэй дээр тийм санал хураалттай асуудлуудаа эхлээд дугаарыг нь өөрчлөөд оруулах хэрэгтэй байна. Ингээд хэлэлцэх асуудлын дараалалд 3 дугаарт танилцуулагдсан Намрын чуулганы 10 дугаар сард батлах Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя, 1 дүгээрт оруулъя. Ажлын хэсэгт 2 дугаарт гэсэн ийм дараалал өөрчлөгдөж байгаа учраас энэ саналаар горимын тийм горимын саналаар, дараа нь хэлчихье. Санал хураалтын, дарааллыг нь өөрчлөх тухай дээр санал хураалт явуулчихъя. 3 дугаар асуудлыг 1 дүгээр асуудал болгож өөрчлөх горимын санал явуулъя, санал хураалт. Санал хураалт цаглавараа эхлээд баталчихъя. Тийм. Горимын санал 100 хувиар дэмжигдлээ. Санал хураалт 100 хувиар дэмжигдсэн учраас дараагийн асуудалд оръё. Ер нь хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Дамдинням гишүүн саналтай байна. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Гишүүд энэ өдрийн мэнд хүргэе. Манай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо нэн даруй энэ 7 хоногтоо байх уу,

ирэх 7 хоногтоо байх уу энэ олимпын бэлтгэл ажлын талаар мэдээллийг Байнгын хороон дээрээ яаралтай сонсох хэрэгтэй байна. Саяхан одоо ингээд энэ Азийн наадам болоод өндөрлөж байна. Монгол Улсын албан ёсны шигшээ багийн 2 тамирчнаас допингийн шинжилгээнд бүдэрсэн тохиолдол гарчихлаа. Олон улсын допингийн холбооноос бол эсрэг холбооноос бол бидний манай улсыг бол хар жагсаалтад оруулна гэсэн онцгой хатуу анхааруулгатай явж байгаа. Олимпын сайдтай болчихсон байгаа, ЗГ-ын гишүүнтэй болоод дээрдээд байгаа юм нэг их харагдахгүй байна. Энэ олимпын сайдыг дуудаж ирж энэ олимпын бэлтгэл ажил нь ямар явж байгаа юм. Допингтой холбоотой энэ маргаан нь юу болоод байгаа юм. Ямар түвшиний ажлууд хийгдээд байгаа юм гэдгийг сонсох хэрэгтэй байна шүү дээ бид нар.

Манай Байнгын хорооны нэр чинь Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо шүү дээ. Энэ 4 чиглэлийн Монголын төрийн хамгийн том бодлого энд яригдаж байх ёстой. ЗГ дээр бол ажлууд хийгдэж л байгаа байх бодвол. Тэгэхдээ Их Хурал энэ дээр анхаарал тавихгүй бол улсынх нь нэр байхгүй олимпын туг доор цагаан туг доор орох эрсдэл бол бодитой болчихсон байна шүү дээ. Тэгэхээр Байнгын хорооны дарга, Байнгын хорооны эрхэм гишүүд бас ойлгож байгаа байх. Дараачийн Байнгын хорооны хурлаар яаралтай энэ асуудлыг оруулж ирж бид нар ярих хэрэгтэй байна. Улсаараа шившиг болоод сууж баймааргүй байна. Засаг замбараагүй болчихсон энэ нөхцөл байдлыг бид нар цэгцлэх хэрэгтэй шүү дээ. Улсын наадам болно, баахан маргаан улс үндэстнээрээ талцана, бас л баахан допингийн асуудал. Их спорт яригдана, их спортод нь зүгээр ингээд л хэвийн үзэгдэл болтлоо тарцгаачихсан. Тэгээд төр засаг гэж байгаа юм бол, улс үндэсний нэр гэж байгаа юм бол бид нар анхаарах ёстой байхгүй юу. Тэгэхээр энийг яримаар байна дарга.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүний бас гаргаж байгаа саналыг бол бас дэмжиж байна. Тэгээд ЗГ-аас энэ допингийн өнөөдрийн байдалтай бас уялдуулж ажлын хэсэг гараад ажиллаж байгаа юм байна лээ. Тэгээд бид бас ирэх 7 долоо хоногт энэ допингийн асуудлаар Спортын сайдыг мэдээ мэдээллийг сонсох ийм тов дараалалд оруулах саналыг хүлээж авлаа. Ирэх 7 хоногийн Байнгын хорооны асуудалд нэмүүлж оруулъя. Хэлэлцэх асуудалдаа орё.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сард Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаварыг батлахаар байгаа. Цаглаварыг та бүхэнд тараасан, түүн дээр өөр саналтай гишүүд байна уу? Ингээд энэ дээр санал хураалт явуулах байгаа.

Санал хураалт, цаглаварыг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ 10 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглавар 100 хувиар батлагдлаа.

13.26 цаг

**Хоёр. “Ажлын хэсэг тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол хэл, бичгийн үнэлэмж, хэрэглээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/**

2 дугаар асуудал, 2 дугаар асуудал Ажлын хэсэг байгуулахаар тогтоолын



төслийг батлах байгаа. Ажлын хэсэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.10 дахь заалтыг үндэслэн Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос тогтоох нь.

1. Монгол хэл бичгийн үнэлэмж, хэрэглээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргаж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх шийдвэрийг төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж байна. Энд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулах саналтай байна. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг, гишүүдэд Б.Жаргалмаа, Ц.Мөнхцэцэг, Ж.Чинбүрэн, Л.Энх-Амгалан нарын гишүүд бас энэ ажлын хэсэгт орж ажиллаж гэсэн ийм санал ирүүлсэн учраас энэ ажлын хэсгийг байгуулна. Ажлын хэсэг дээр саналтай гишүүд байна уу? Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Энэ чухал ажлын хэсэгт миний бие өөрөө бас ажиллах сонирхолтой байгаа учраас ажлын хэсэгт миний нэрийг оруулж өгнө үү гэсэн санал гаргаж байна. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Баярсайхан гишүүний саналыг нэмж оруулъя. Энх-Амгалан сайд саналаа хэлье.

**Л.Энх-Амгалан:** Ингэе, Баярсайхан гишүүний саналыг дэмжиж байна. Тэгээд би нэрээ татаад, миний оронд Баярсайхан гишүүнийг нэмээд ажлын хэсэгт оруулчихъя. Энэ жаахан зохимжтой болов уу гэж бодож байна. Би өөрөө мэргэжил арга зүйн бас нөгөө зөвлөгөө өгч оролцох учраас бол шууд ажлын хэсгийн гишүүн болж оролцоход бас жаахан яах байх, зохимжгүй харагдах байх.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдыг оронд Баярсайхан гишүүн оръё гэсэн санал оруулсан учраас Баярсайхан гишүүнийг оруулаад ингээд ажлын хэсэг

4, 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг байгуулах энэ тогтоолыг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ санал 88,9 хувиар дэмжигдлээ. Мөнхцэцэг гишүүний, Ц.Мөнхцэцэг гишүүний тийм кноп ажиллаагүй учраас дэмжсэнд тооцож протоколд тэмдэглүүлье.

13.29 цаг

**Гурав.Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын талаарх Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох**

3 дугаар асуудал боловсрол, шинжлэх ухааны энэ салбарын Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалт сэдвээр Шинжлэх ухаан, Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсохоор байгаа. Ингээд сайдын мэдээллийг сонсьё. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийг. Сайдын микрофоныг өгье, Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгаж байна. Тэгээд өнөөдөр бас манай Байнгын хорооны хурлаар бас манай салбарын мэдээлэл энэ жилийн шинэ хичээлийн жилийн бас онцлогтой холбоотой салбарын бодлогын яамнаас хэрэгжүүлж байгаа ажлуудын талаар бас мэдээллүүдийг товч мэдээллүүд бэлдсэн байгаа. Тэгээд би ингэе гэж бодож байна. Нэгэнт гишүүдэд бас нэлээн дэлгэрэнгүй танилцуулгууд оччихсон, тэгээд статистик мэдээллүүдийг бол би нуришихгүй явчихъя гэж бодож байна. Тэгээд үндсэндээ бол энэ жилийн шинэ хичээлийн жилийн онцлог Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилт дээр онцолж хийж байгаа ажлуудынхаа талаар товчхон мэдээлэл өгөөд, тэгээд юуны цэцэрлэгийн хүртээмж, 3 ээлжийн сургуулийн

эрсдэлийн асуудлаар авч хэрэг хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын хүрээнд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, тэгээд чанар, үр дүнд суурилсан боловсролын үнэлгээний чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд, түүний үр дүнгүүд, тэгээд хүртээмжээс чанарт чиглэсэн санхүү, хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлүүдийн талаар бас товч мэдээлэл өгөөд, 24 оны төсөв дээр ямар зарчим барьж байгаа вэ гэдэг талаар товчхон мэдээлэл өгчихье гэж бодож байна.

Монгол Улсын Их Хурлын 23 оны хаврын чуулганаар Боловсролын багц хууль батлагдаж гарснаар манай салбарт үр дүн чанар, гүйцэтгэлд суурилсан энэ эрх зүйн шинэчлэлийн энэ үндэс бүрдсэн байгаа. Бид нар 6 шинэчлэлийг зарласан энэ хуулиараа. 1 дүгээрт нь бол хөтөлбөрийн шинэчлэл хийнэ. Аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгал мэдлэгийн эдийн засгийг бий болгох Монгол дэлхийн Монгол иргэнийг бэлдэхэд бол одоогийн манай хөтөлбөр дээр тодорхой шинэчлэлүүд хийх шаардлага гарсан учраас хөтөлбөрийн шинэчлэл 1 дүгээрт хийе. 2 дугаарт бол чанар, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцооныхоо шинэчлэлүүдийг бид нар хийе. Боловсролд зарж байгаа санхүүжилтийг боловсролыг үр дүнтэй шууд уясан, гүйцэтгэлтэй шууд уясан суурилсан ийм санхүүжилтийн тогтолцоонуудыг хийе. 3 дугаарт бол багшийн хөгжлийн асуудал дээр бас Монгол Улс багшаа яаж бэлдэх юм бэ, өгссөн багш хүрч ирээд ажлын байр дээр яаж тасралтгүй хөгжих юм, эргээд багшийн цалин урамшуулал, нийгмийн баталгаа, нийгэмд байгаа багшийн нэр хүндийн асуудлуудыг яаж өргөх вэ гэдэг 3 дугаар цогц бодлогын асуудлууд. 4-д нь бол Монгол Улсын үнэлгээний тогтолцооны асуудал дээр тодорхой шинэчлэл хийнэ. 5-д нь бол мэдээж улс төрөөс хараат байсан энэ боловсролын засаглалын асуудал дээр

тодорхой мерит зарчим дээр суурилсан чадамжид суурилсан засаглалын шинэчлэлүүдийг хийе. 6-д нь бол цахим шилжилтийг хийж, хот хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгаж, энэ 6 шинэчлэлийг бид нар сайн хийж чадах юм бол хамгийн сайн сургууль бол гэрт ойрхон сургууль байх энэ тогтолцоог бид нар Монголд хөрсөн дээрээ буулгах ийм боломжууд байна гэж харж байгаа.

Ингээд энэ шинэ хичээлийн жилийн онцлог бол яг энэ Боловсролын багц хуулиар тодорхойлогдсон саяын миний дурдсан 6 том реформ шинэчлэлийг хийх, боловсролын сэргэлтийг хийх ийм шинэ хичээлийн жил гарааны жил гэж ойлгож болно. Тэгээд энэ хүрээнд бол бид нар шинэ хичээлийн жилийг бол сургуулийн менежментийг сайжруулах жил болгож зарлаж, цаашидаа бид нар хүртээмжээс чанарт ямархуу бодлогын арга хэмжээнүүдийг авах вэ гэдэг чиглэлээр бас нэг хэд хэдэн ажлууд хийснээ та бүхэнд товч мэдээлэл өгье гэж бодож байна.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд бид нар бас энэ СӨБ-ын хүртээмжийг сайжруулах чиглэлээр Улаанбаатар хотод олон жил сугалааны цэцэрлэгийн тогтолцоог бид нар халсан. Энэ дээр бас тодорхой үр дүнгүүд бас гарсан байгаа. Ингээд энэ жил бас бид нар энэ өнгөрсөн онд хийсэн амжилтаа бататгаж ямар ч байсан ИМонгол системээр бүртгүүлсэн хүүхдүүдийн бүртгүүлсэн хүүхэд бүрийг цэцэрлэгийн гадна үлдээхгүй байх энэ цэцэрлэгийн хүртээмжийн асуудлыг бас бид нар шийдвэрлэж чадлаа гэж бас бид нар хэлье гэж бодож байна. Ингээд цаашидаа бол энэ хүүхдийн цэцэрлэгийн насны хүүхдийг бид нар хуулиараа 3-аас 5 нас байсныг 2-оос 5 нас болгосон учраас бас хүртээмж дээр тодорхой асуудлууд шийдлүүд гарах шаардлага байгаа. Энэ хүрээнд бол Улаанбаатар хотыг шийдсэн энэ туршилагыг Баян-Өлгий аймаг, Хөвсгөл аймаг, Өвөрхангай аймаг, Дархан, Эрдэнэт гэсэн хүн ам нь өсөж



байгаа цэцэрлэгийн насны хүүхдүүдийн хүн амын хүртээмжийг шийдэх шаардлага үүсэж байгаа, эрэлт хэрэгцээ үүсэж байгаа энэ аймгууд дээр бас тодорхой энэ бодлогын шийдлүүдийг бас өргөжүүлж ажиллая гэсэн ийм чиглэлтэй байна.

Цэцэрлэгийн хүртээмжийг шийдэхэд бол бид нар хэд хэдэн шийдлүүдийг Улаанбаатар хотод гаргасан. Энэ бол 6 төрийн өмчит цэцэрлэгийн сургуулийн өргөтгөлийн барилгуудыг өргөтгөсөн. Орон сууцын нэг давхар бие даасан цэцэрлэгийн барилгуудыг бас худалдан авалтууд хийж, цэцэрлэг болгож зохион байгуулсан. Байршил, ачаалал өндөр байршилд байгаа цэцэрлэгийн барилгуудын барилгын засвар, орчин үеийн бас технологи ашигласан цомцог технологийг ашиглаж бид нар 11 цэцэрлэгийн асуудлуудыг шийдсэн байгаа. Мөн тодорхой юуны нэг давхрын орчин үеийн юуны орон сууцын нэг давхрын барилгуудыг бид нар худалдаж авч мөн түрээсэлж бас тодорхой энэ цэцэрлэгийн хүртээмжүүдийг шийдсэн. Ийм шийдлүүдийг бид нар гаргаж чадсан учраас өнөөдөр цэцэрлэгийн хүртээмж дээр бол тодорхой үр дүн гарлаа гэдгийг бас би хэлье гэж бодож байна.

Ингээд өнгөрсөн 2 жилийнхээ цэцэрлэгийн хүртээмжийг шийдсэн туршилага дээр үндэслэж бид нар энэ намрын хичээлийн жилийн бас нэг онцлог бол ер нь улсын хэмжээнд юу 3 ээлжийн эрсдэлд орох ёстой сургуулиуд дээр бид нар бас тооцоо судалгаанууд хийж, ер нь богино болон дунд хугацаа, урт хугацаанд ер нь ямархуу шийдлүүд байх вэ гэдэг энэ шийдлүүдийг гаргаж ЗГ-ын хуралдаанд 3 удаагийн танилцуулга хийж, ЗГ-ын тогтоолуудыг гаргаж бас ажиллаж байна. Ингээд улсын хэмжээнд бид нарын хийсэн судалгаагаар бол нийт 67 сургууль, түүнээс бол Улаанбаатар хотод бол 47 сургууль бол 3 ээлжид орж байгаа. Цаашдаа 3 ээлжид орох ийм

эрсдэл үүсэж байгаа ийм сургуулиуд байна гэж харж байгаа.

Тэгээд яагаад ерөнхийдөө энэ Улаанбаатар хотод 3 ээлжид орох эрсдэлүүд үүсэж байна вэ гэдэг гол шалтгаануудыг бид нар бас тодорхойлсон байгаа. 1 дүгээр шалтгаан бол үндсэндээ ЕБС-ийг жилд дунджаар 30-аас 35 мянган хүүхэд төгсөж байхад доороос 1 дүгээр ангид 78-аас 80 мянган хүүхэд шинээр элсэж орж байгаа. Ингээд элсэлт төгсөлтийн энэ зөрөөтэй байдал бол ойрын 5 жилд үргэлжилнэ гэж бид нар харж байна. Ингээд хүүхдийн 50-иас дээш хувь нь нийслэлийн сургуулиудад энэ үүсэж байгаа шинэ ачааллын 50-иас дээш хувь нь нийслэлд үүсэж байна. Ингээд ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын тоо 25 онд 56 хувиар, 30 онд 71 хувиар өсөх тооцоолол байгаа.

ҮСХ-ны 22 оны суурин хүн амын тоо, 5 настай хүүхэд болон ЕБС-ийн төгсөгчдийн тоонд үндэслэж 30 он хүртэлх төлөв байдлыг авч үзэхэд 23-аас 24 оны хичээлийн жилд нийслэлд 385402 мянган суралцагч ерөнхий боловсролын үйлчилгээнд хамрагдах бөгөөд өмнөх оноос 20 мянган суралцагч 20600 суралцагчаар нэмэх ийм хэрэгцээ шаардлагууд үүсэж байна гэж ойлгож болно. Судалгаагаар хэт өндөр ачаалалтай ерөнхий боловсролын Улаанбаатар хотод байгаа 54 сургуулийн 33 мянган хүүхдийн хүчин чадлаас хэтрэх буюу сургуулийн гадна үлдэх ийм эрсдэл бодитой эрсдэл үүссэн. Зөвхөн ирэх хичээлийн жил гэхэд 23 оны 9 сарын 1-ний өдрөөр нийслэлийн хэмжээнд 20 мянган хүүхдийн суудал бүхий сургалтын шинэ орчныг бүрдүүлэх ийм зайлиггүй шаардлага үүсэж байгаа.

Ингээд нийслэлийн сургуулиудын ачааллыг тэнцвэржүүлэх хүрээнд бид нар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Энэ 1 дүгээрт нь бол шинэ сургууль өргөтгөлийн ашиглалтад орох ёстой барилгуудыг бид нар

эрчимжүүлж нэлээн ажиллаж байгаа. Энэ зунжингаа бид нар бас нэлээн нийслэл дээр ажиллаж, хэд хэдэн сургуулиудын 24, 25 он руу шилжих гэж байсан хөрөнгө оруулалтуудыг бид нар нааш нь шахаж, тодорхой төсөв дотроо зохицуулалт хийгээд ингээд энэ хичээлийн жилдээ орж, ашиглалтад оруулах ийм ажлуудыг бид нар зохион байгуулсан гэсэн. Би нэг баян юу СХД-ийн 12 дугаар сургууль бол хамгийн олон хүүхэдтэй. Тэгээд сургуульгүй сургууль байгаа. Энэ дээр Улсын Их Хурлын гишүүдтэйгээ хамтарч ажиллаж ингээд тодорхой ЗГ дээр шийдвэр гаргаж ажиллуулсан учраас энэ бол яг одоогийн явсан 23 оныхоо батлагдсан төсвөөр явсан бол 25 он руу ашиглалтад орох ийм сургууль байсан. Энийг ямар ч байсан наашлуулж гүйцэтгэлээр нь санхүүжүүлснээр бид нар энэ оны хичээлийн жилдээ багтаж ашиглалтад оруулах ийм боломжууд бас гарч байгаа. 5 дугаар сургууль, 71 дүгээр сургууль, 12 дугаар сургууль.

БЗД-ийн 26 дугаар хороо дээр байсан 2 сургууль, 1 цэцэрлэгүүдийн асуудлуудыг бид нар нийслэлтэйгээ хамтарч дэд бүтэц дээр шаардлагатай байсан 5,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтуудыг шийдэж чадсанаар бол яг нийслэл дээр хамгийн гал ассан цэг болсон 6 цэг дээр бид нар тодорхой сургуулиудыг 9 сарын 1, 10 сарын 1, 11 сарын 1, 12 сарын 1 гэсэн хуваарьтайгаар бас ашиглалтад оруулж ингэж ажиллаж байна.

Цаашидаа бас сургалтын зориулалтын хичээлийн байруудыг түрээслэх ийм хэрэгцээ шаардлагууд бас гарч байгаа. Энэ хүрээнд бид нар бол цаашидаа ерөнхийдөө газаргүй Хан-Уул дүүрэг, БЗД дээр газрын асуудлууд маш их хүндрэлтэй. Төрийн өмчийн сургуульгүй ийм томоохон хорооллууд үүсэж байгаа учраас бол энэ дээр сургуулийн бус зориулалтаар барьсан барилгуудыг худалдаж авч, сургуулийн зориулалттай болгох энэ ажлуудыг бас

бид нар хийж эхэлье гэсэн ийм тооцоо судалгаануудыг хийж байна. Энэ жилийн хийсэн нэг шинэ зүйл бол бид нар ноднин цэцэрлэгийн хүртээмжийг шийдсэнтэй адилхан сургуульгүй байгаа томоохон энэ хорооллууд дээр яг цэцэрлэгийг шийдсэнтэй адилхан бага сургуулиудыг бид нар бас зохион байгуулах эхний туршилтын төслүүдийг бид нар хэрэгжүүлж бас тодорхой амжилтад хүрч байна. Энэ бол Алтай хотхон дотор бид нар энэ жил шинэ бага сургуулиудыг байгуулснаар хүүхдүүд, цэцэрлэг гэхгүйгээр цэцэрлэг, бага сургуулийн насны хүүхдүүд гэрийнхээ ойролцоо сургуульдаа сурах энэ боломжуудаар хангах ийм шийдлүүдийг бол бид нар бас харж байгаа.

Мөн дотоод нөөц бололцоогоо ашиглаж засвар тохижилтуудыг бас хийж, зарим сургуулиудын 3 ээлжийн сургуулийн эрсдэлд орж байгаа сургуулиудын асуудлуудыг бас шийдэж байна. Хамран сургах тойргоор бас тодорхой зохицуулалтууд хийж байгаа ийм шийдлүүдийг хийсэн. Хамгийн гол нь нийслэлд энэ сургуульгүй болсон гол шалтгаан юу байсан бэ гэхээр бол яг энэ газар олголттой холбоотой. Улсын комисст авч байгаа энэ процессуудыг бидэнд нэлээн ил тод болгохгүй бол энэний цаана жинхэнэ ийм сургуульгүй болох ийм асуудлууд үүсдэг юм байна. Би зөвхөн нэг жишээ дурдахад Улаанбаатар хотод томоохон хороолол барих гэж байгаа компаниуд эхлээд зураг төслийн ажлуудыг хийхдээ, архитектур төлөвлөлтийн даалгаврыг хотоос авахдаа яг сургууль, цэцэрлэгээ төлөвлөчихдөг. Дахиад ажил эхлэх зөвшөөрөл авахад тэр сургууль, цэцэрлэг нь байдаг. Гэтэл яг Улсын комисст авахдаа хорооллоороо өгдөггүй, байшин байшингаар нь ингээд зараад явчихдаг учраас өнөөдөр нийслэл дээр яг ингээд нэг ийм улсын комиссын авлигын сүлжээ юм даа нэг талын тийм ээ, ийм авлигын сүлжээ үүссэн учраас бол өнөөдөр олон хорооллууд дээр энэ сургууль, цэцэрлэггүй болох ийм бодитой эрсдэлүүд үүссэн

байна гэдэг ийм шалтгаануудыг бид нар олсон учраас Монгол Улсын ЗГ-т энэ асуудлуудыг оруулж, цаашидаа энэ архитектур төлөвлөлтийн даалгавар, ажил эхлэх төлөвлөлтийн даалгавар, улсын комисс авах шат шатлалд боловсролын байгууллагуудын төлөөллүүдийг оруулсан ийм хяналт шалгалтын ажлуудыг яг шатлал шат бүр дээр нь оройтохгүйгээр авах ийм зохицуулалтуудыг бас хийж ажиллаж байна гэдгийг бас та бүхэнд хэлье.

Ингээд өнөөдрийн байдлаар энэ хэлбэрээр ажиллаж бид нар 11 шинэ сургууль өргөтгөлийг ашиглалтад оруулж, 6240 хүүхдийн сургуулийн шинэ боломжийн асуудлуудыг бүрдүүлсэн. Ингээд 17145 хүүхдийн багтаамжтай 27 сургалтын зориулалттай 27 барилга байгууламжийг түрээсэлж байна. 13 барилга байгууламжид бид нар засвар тохижилт хийж, 4 сургуулийн хамран сургах тойргийн зохицуулалтаар нийт мянга гаруй хүүхдийн асуудлуудыг шийдвэрлэсэн ийм ажлуудыг бас энэ жил шинэ хичээлийн жилдээ багтааж хийлээ гэдгийг бас онцолж хэлье гэж бодож байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд бид нар бас шинэ хууль, эрх зүйн орчинд ажиллаж байгаа. Нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардлын аргачлалуудыг өөрчилж, тухайн ямар мэргэжлээр хүүхэд мэргэжлийн боловсрол дээр, техникийн боловсрол дээр сурч байна вэ гэдгийг тухайн мэргэжлийн өртөгт суурилсан санхүүжилтүүдийг хэрэгжүүлж эхэлснээрээ энэ бол тодорхой үр дүн гарах ийм шинэ он жилүүд эхэлж байгаа гэдгийг бас би онцолж хэлье гэж бодож байна. Хуучин манай ард иргэдийн дунд байсан ТМС гэдэг ойлголтыг бид нар ер нь арилгая. Энэ бол цаашаа мэргэжлийн болон техникийн боловсролын коллеж хэлбэрээр энэ сургуулиудыг зохион байгуулах энэ ажлуудыг бас энэ хичээлийн жилд бид нар онцолж хийж байна.

Ингээд бид нар Дархан-Уул, Орхон, Дорнод аймагт байрлаж байгаа нийт 7 мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн сургуулиудын ангиллыг өөрчилсөн, коллеж болгосон байгаа. Мөн Булган, Сэлэнгэ, Төв аймаг, Хөвсгөл, Өмнөговь аймгууд дээр байгаа мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг төрийн өмчийн их сургуулийн харьяа болгож нэгтгэж, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн цогцолбор хэлбэрээр хөгжүүлэх шатлан суралцах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр бас бодитой ажлуудыг хийж эхлүүлсэн. Энэ жилийн, энэ жилийн шинэ хичээлийн жилийн гол онцлог бол бид нар олон улсын хөтөлбөрүүдийг энэ мэргэжлийн болон техникийн боловсролын коллежуудаар хэрэгжүүлж эхэлж байна. Pearson гэж компанитай хамтарч, бид нар компьютерын программистуудыг бэлдэх энэ хөтөлбөрүүдийг мэргэжлийн коллежуудаар шинэ хичээлийн жил дээр бас эхэлж байгаа.

Мөн Коосэн гэж Японы тогтолцоог бид нар 3 сургууль дээр, одоо 3 сургууль байгаа, нэмж 3 сургууль дээр энэ Коосэн сургалтын хөтөлбөрүүдийг нэвтрүүлж эхэлсэн, шинэ ажлуудыг бас зохион байгуулж байгаа. Шинэ хичээлийн жилийн мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын онцлог бол энэ хосмог сургалтууд буюу энэ ажлын байран дээр сургалт хийж, яг ирээдүйд ажиллах ажлын байран дээрээ, ирээдүйд ажиллах ажлынхаа ажил олгогч нартаа тодорхой сургалтууд хийж, ажлаа ажлаа хийгээд, ажлын байран дээрээ хийгээд сургах энэ тогтолцоог бас нэвтрүүлж ажиллаж байна. Энэ бол тодорхой үр дүн өгч байгаа.

Ингээд шинэ батлагдсан Хөдөлмөрийн хуулиар Хөдөлмөр эрхлэлтийн сангаас энэ ажлын байран дээрээ дадлага хийж, суралцаж байгаа хүүхдүүдийн НДШ-ийг нөхөн ажил олгогчид нь олгодог ийм зохицуулалт бий

болсон учраас энэ бол нэлээн тодорхой хөшүүрэг дэмжлэг болж байгаа гэдгийг бас би онцолж хэлье гэж бодож байна. Тэгээд цаашидаа бид нар мэргэжлийн боловсролынхоо болон дээд боловсролын энэ хичээлийн жилийн төлөвлөлтүүдийг өөрчилж байгаа. Жишээ нь хөдөө аж ахуйн чиглэлээр сурч байгаа, зам, тээврийн чиглэлээр сурч байгаа, барилгын чиглэлээр сурч байгаа мэргэжил эзэмшиж байгаа хүүхдүүдийг бол яг ид сезоны үеэр нь ажлын юу ажлын байр дээр нь, дадлагын бааз дээр нь ажиллуулж, тодорхой кредитүүдийг нь тооцох ийм уян хатан сургалтын төлөвлөлтүүдийг бас хийж ажиллаж байгаа гэдгийг бас би онцолж хэлье гэж бодож байна.

Дээд боловсролын түвшинд бол мэдээж бас шинэ бол хуулийн эрх зүйн орчинд бид нар үйл ажиллагаагаа эхэлсэн. Ингээд цаашидаа бол бид нар энэ дээд боловсролын салбарт чанарын шинэ өөрчлөлтүүдийг гаргах чиглэл рүү нэлээн томоохон арга хэмжээнүүдийг авч байна. Өнгөрсөн жилийн хугацаанд бид нар 27 их, дээд сургуулиудын сургалтын үйл ажиллагааны зөвшөөрлийг цуцалсан. Ингээд инженер техникийн чиглэлийн 3 сургуулийг бас ЗГ-ын тогтоолоор шинээр байгуулж, тусгай чиг үүргийн сургуультай нийлүүлж, өнөөдрийн байдлаар 65 их, дээд сургуулиуд өнөөдөр Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулж байна. Өчигдөр бас бид нар Английн Times High education гэж олон улс, дэлхийн их дээд сургуулиудын эрэмбэ тогтоодог байгууллагатай хамтарч арга зүйн зөвлөмж авч Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа их дээд сургуулиудын эрэмбийг өчигдөр бид нар албан ёсоор зарласан.

Энэ дээр бол энэ эрэмбэ зарласнаар энэ Times High education-ний арга зүйгээр хийсэн шинэ үнэлгээгээр бол одоо үйл ажиллагаа явуулж байгаа 65 их дээд сургуулиудын дөнгөж 30 хүрэхгүй хувь нь 50-иас дээш хувийн сургалтын чанарыг үзүүлж байна гэдэг ийм ерөнхий

үнэлгээнүүд бас гарсан байгаа. Тэгээд цаашидаа бол шинэ хуулиар их сургууль, коллеж гэдэг 2 тогтолцоонд бид нар шилжиж байгаа. Тэгээд чанарын үнэлгээгээ үнэлгээ дээр муу үзүүлэлтүүд авч байгаа яг их сургуулийн хэмжээний статусын хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадахгүй байгаа коллеж юу, дээд сургуулиудыг бид нар коллеж болгож зохион байгуулах ийм хэрэгцээ шаардлагууд бас үүсэж байна гэж харж байна. Мөн төрийн өмчит 6 их, дээд сургуулиудын нэгдэл буюу дундын удирдах зөвлөлүүдийг байгуулж, цаашидаа бид нар Монгол Улсад судалгааны их сургуулийг, үндэсний их судалгааны их сургуулийг байгуулах чиглэл бас нэлээн томоохон бас ажлуудыг хийж байгаа гэдгийг бас онцолж хэлье гэж бодож байна.

Мөн Боловсролын зээлийн сан дээр тодорхой өөрчлөлтүүдийг хийсэн. Нийгэм дээр энэ бол нэлээн том доржилт үүссэн энийг та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд цаашидаа бол энэ Боловсролын зээлийн сангийн хүртээмжүүдийг нэмэгдүүлэх чиглэл рүү заавал ч үгүй шилдэг дэлхийн шилдэг 100-д явах биш, тухайн мэргэжлээрээ дэлхий дээр аль сургууль тэргүүлж байна тэр сургуульд тэр Монгол оюутнуудыг дэмжиж суралцах асуудлуудыг дэмжих ийм тогтолцоо руу бид нар шилжүүлж ажиллаж байна гэдгийг бас та бүхэнд онцолж хэлье гэж бодож байна.

Ингээд үндсэндээ энэ хичээлийн жилийн онцлог, яг чанар дээр яг бодитой ямар өөрчлөлтүүд гарч байгаа вэ гэдэг зүйл дээр 2 зүйлүүдийг хэлье гэж бодож байна. Энэ бол бид нарын сүүлийн 2 жилд хийж байгаа энэ гүйцэтгэлийн үнэлгээний асуудал байгаа. Чанарын үнэлгээний асуудал, сургуулийн үнэлгээ, багийн үнэлгээ дээр бид нар шилжиж 2 дахь жилийнхээ үнэлгээг бид нар сая албан ёсоор зарласан. 23 оны багийн ажлын гүйцэтгэл үр дүнгийн үнэлгээнд нийт төрийн өмчийн 681 сургуулийн 23 мянган багш, нийт 912 мянган суралцагч



нар хамрагдсан ийм үнэлгээ хийгдсэн. 22 оны гүйцэтгэлийн үнэлгээний ерөнхий дүнгээр ЕБС-ийн багшийн гүйцэтгэлийн улсын дундаж 22 оны 22 оны дүн 72,5 байсан бол 23 онд 75,7 хувь болж бас нэмэгдсэн ийм сайн үр дүн гарсан байгаа. Энэ бол эргээд боловсролын чанарт эергээр нөлөөлөх ийм үр дүн юм байгаа юм гэдгийг бас онцолж хэлье гэж бодож байна.

Энэ жилийн ерөнхий боловсролын энэ жилийн үнэлгээнд ерөнхий боловсролын нийт багш нарын 41,9 гүйцэтгэлийн үнэлгээний юу өнгөрсөн жил нийт багш нарын 41,9 хувь нь гүйцэтгэлийн үнэлгээний урамшуулал авч байсан бол 23 онд нийт багш нарын 51,7 хувь, цэцэрлэгийн багш нарын 41,7 хувь энэ урамшууллыг авч байсан бол энэ жил 50,6 хувь болж гүйцэтгэлийн урамшууллын үнэлгээ авах багш нарын тоо нэмэгдэж байгаа, эргээд энэ боловсролын чанарыг дээшилж байгаа ийм бодитой ахицууд гарч байна. Бид нар хүүхдүүдийг хооронд нь өрсөлдүүлдэг, багшийг хооронд нь өрсөлдүүлдэг, сургуулийг хооронд нь өрсөлдүүлдэг байсан энэ тогтолцооноос салж зөвхөн ахиц дэвшлийн үнэлгээний ийм тогтолцоонд бас ингэж шилжиж байна гэдгээ бас би онцолж хэлье гэж бодож байна.

Ингээд өмнө нь бас би хэлсэн. БШУЯ-наас 23 оныг сургалтын сургууль, цэцэрлэгийн менежментийг сайжруулах жил болгож зарласан. Цаашидаа бол бид нар энэ сургууль, цэцэрлэг, сургуулийн байгууллагын менежментийн ажлуудыг үнэлэхдээ ийм 6 багц асуудлаар үнэлдэг болъё. 1 дүгээрт нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт хөтөлбөрийг хэрэгжүүлж байна вэ гэдгээр үнэлдэг болъё. 2 дугаарт нь хүүхдийн хөгжил хамгааллын асуудлуудаар хэр орчин бүрдүүлж ажиллаж байна вэ гэдгээр бас тодорхой үнэлгээний том шалгуур болгож байгаа. Энэ бол бас нийгэмд өнөөдөр үүсэж байгаа гол асуудлууд нь хүүхдийн хөгжил хамгааллын асуудлууд.

Энэ дээр бол тодорхой ахиц дэвшилүүд гаргах. Ер нь сургуулийн удирдлага хамт олон бол энэ хүүхдэд хот хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгаж, яг адил тэгш сурах орчин, хүүхдийн хөгжих орчныг хамгаалал энэ орчныг бий болгож чадаж байна уу гэдэг бол хамгийн том ийм үзүүлэлтүүд байх ёстой юм гэж харж байгаа.

3 дахь үзүүлэлт бол энэ багшийн тасралтгүй хөгжлийг хэр зэрэг дэмжиж байна вэ гэдгээр бид нар үнэлдэг болж байна. 4 дүгээрт нь бол удирдлагын манлайллын асуудал байгаа. Цэцэрлэг, сургуулиа хэр зэрэг удирдаж байгаа вэ, бизнес төлөвлөгөөгөө яг зөв гаргаж чадаж байна уу, энэнийхээ хэрэгжилт дээр хяналт мониторинг хийж чадаж байна уу, үнэхээр яг жинхэнэ тийм мерит зарчмаар удирдах ийм чадвар байгууллагын бүтцүүд, энэ соёлууд суусан байна уу гэдгээр бас үнэлдэг болж байгаа. Сургалтын орчныг бас бүрдүүлж чадаж байна уу. 6-д нь бол олон нийтийн оролцоо буюу эцэг эхийн, асран хамгаалагчдын хамтын ажиллагааны чиглэлээр ямар ажлууд хийгдэж байна вэ. Ер нь энэ сургуулийн үйл ажиллагаа хэр зэрэг нээлттэй байна вэ гэдэг ийм 6 багц асуудлын хүрээнд бид нар энэ боловсролын үнэлгээг зохион байгуулдаг болж байна.

Ингээд боловсролын сургалтын байгууллагын үнэлгээгээр өмнөх жилд нийт ЕБС-ийн 40,3 хувь урамшуулал авдаг байсан бол 23 онд 47 хувь болж өссөн байна. Мөн нийт цэцэрлэгийн 42,2 хувь нь байгууллагын урамшуулал авч байсан бол 23 онд 41,7 хувь болж ахицууд гарсан байна. Цаашидад ч гэсэн амжилтаа ахиулсан хувь хэмжээгээр нь багшийг урамшуулах хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бэхжүүлж, чанарыг үнэлдэг тогтолцоог сайжруулах чиглэл рүү хэрэгжүүлнэ.

Ингээд сая мөн Монгол Улсын ЗГ-аас энэ багшийг дэмжих 3 тулгуурт



бодлогыг бас баталсан. Багиийг сургах тогтолцоо, багиийг ажлын байран дээр тасралтгүй хөгжүүлэх тогтолцоо, тэгээд цаашидаа багиийн цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах чиглэл рүү бас энэ тогтолцооны шинэчлэлүүдийг хийх ажлуудыг хийж, цаашидаа хамгийн сайн багш хамгийн өндөр урамшуулал авах энэ тогтолцоо руу бид нар алхаж байна. Энэ жилээс шинэ I сарын I-нээс эхэлж гүйцэтгэлийн үнэлгээний нэг дүгээр эрэмбэ дээр эрэмбэлэгдсэн багш нар бол нийт цалингийн 50 хувь, 50 хүртэлх хувиар урамшуулал авах энэ боломжууд бас нээгдэж байгаа гэдгийг бас онцолж хэлье гэж бодож байна.

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарт 23 оны байдлаар нийт 468 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа. Хамгийн том төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа, хамгийн олон төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа салбар бол манай салбар. Ингээд Монгол Улсын 23 оны төсвийн тухай хуульд нийт 399 төсөл, арга хэмжээ батлагдаж, барилга угсралтын төсөл, арга хэмжээ 23 оны 10 сарын 1-ний байдлаар улсын хэмжээнд 55,1 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. 23 оны 10 сарын 13-ны байдлаар 43 барилга байгууламж ашиглалтад орсон. Үүнээс нийт 5720 хүүхдийн суудалтай 12 барилга, 2710 ортой 21 цэцэрлэгийн барилга, 280 хүүхдийн хүчин чадалтай нэг цогцолбор, 450 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны 4 барилга, 2 спорт заал, боловсролын байгууллагаас 2 барилга, 1 шугам сүлжээг тус тус ашиглалтад оруулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнээс төсөвт өртөгтөө багтаж ашиглалтад орох боломжгүй 187 төсөл, арга хэмжээ байгаа. 2012 оноос хойш хэрэгжиж байгаа дуусдаггүй ийм сургууль, цэцэрлэгүүд байна. Энэ

дээр ингээд нийт 143 төсөл, арга хэмжээнүүд дээр магадлан хийлгэж, нэмэлт 270 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шаардлагатай байгаа тооцоо гаргаж байгаа. Ингээд бид нар Улсын Үндэсний аудитын газартаа энэ 187 арга хэмжээнээс өнөөдөр 123 төсөл, арга хэмжээнд дүгнэлт хийлгүүлж, 2024 оны улсын төсөвт тусгахаар Улсын Их Хуралд бас өргөн бариад байгаа. Ингээд үлдсэн 44 төсөл, арга хэмжээн дээр магадлал гаргуулахаар бид нар Барилгын хөгжлийн төвд хандаж байгаа боловчиг 17 төсөл, арга хэмжээ нь, 17 үүнээс гэрээ байгуулсан 17 арга хэмжээ батлагдах магадлах боломжгүй 6 төсөл, арга хэмжээнүүд бас байгаа.

Энэ жил нийт бид нар 27 сургууль, цэцэрлэгүүдийн гэрээг цуцалж, хар жагсаалтад оруулж байгаа. Энэ яагаад ингэж оруулж байна вэ гэхээр олон жил тендерт маш бага үнээр ороод, тэгээд жил бүхэн ингээд өөрийнхөө төсөвт өртгийг нэмдэг ийм тендерийн хонгил үүссэн байна, үүгээр мэргэисэн компаниуд үүссэн байна. Тийм учраас ингээд бид нар цаашидаа ингээд энэ компаниуд дээр тодорхой хариуцлага хүлээж, хүүхдийн эрхийг зөрчиж байгаа, төрд үзүүлж байгаа энэ хохирлуудыг шүүхээр нэхэмжлэх арга хэмжээнүүдийг авч, бид нар 27, 23 юунууд компаниудыг хар жагсаалтад оруулж ингэж зарласан ийм арга хэмжээнүүдийг авлаа.

Бид нар Монгол Улсын ЗГ 20-оос 24 онд бол ЗГ-ын мөрийн хөтөлбөрт 273 цэцэрлэг ашиглалтад оруулж, 200 шинэ сургууль ашиглалтад оруулна гэдэг ийм зорилтыг манай ЗГ тавьсан. Энэ зорилт бол үндсэндээ 24 онд биелж байгаа. ЗГ-ын зорилт 100 хувь биелж байгаа гэж ойлгож болно. Энэ ажлын хүрээнд улс, орон нутаг, гадаадын зээл тусламжийн хүрээнд төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, зорилтыг хангахаар төлөвлөж ажиллаж, 20 онд 43 сургууль, 60 цэцэрлэг, 21 онд 23 сургууль, 43 цэцэрлэг, 22 онд 34 цэцэрлэг 46 цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 23 оны

12 дугаар сарын 31-ний байдлаар 128 сургууль, 195 цэцэрлэг ашиглалтад орохоор байна. Ингээд энэ ажлыг эрчимжүүлж эрчимжүүлснээр 24 оны хавар бол бид нар ЗГ-ын 273 цэцэрлэг, 200 сургууль барих энэ зорилтдоо хүрч, энэ зорилт биелэх ийм үндэснүүд бас бүрдлээ гэдгийг бас би та бүхэнд хэлье гэж бодож байна.

Ингээд 24 оны боловсролын салбарын төсвийн төслийг салбарт хэрэгжүүлж байгаа чанар, гүйцэтгэл, үр дүнд суурилсан шинэчлэлийг хэрэгжүүлэхээр үндсэн үзүүлэлтүүд хувьд урьд жилүүдтэй харьцуулахад өссөн дүнгээр боловсруулаад байна. Ингээд ирэх хичээлийн жилийн төсөв чанартай боловсрол эзэмших, тэгш боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн хүртээмжээс чанарт чиглэж байгаа бас хэд хэдэн онцлог ажлууд байгаа. Энэ бол хамран сургах сургалт хамран сургалтыг нэмэгдүүлнэ, бүлэг дүүргэлтүүдийг бид нар багасгая гэж бодож байгаа. Цаашидаа нэг ангид шинээр бүлэг үүсэж байгаа бүлгүүдийг бид нар 45, 3 ээлжийн сургуулиуд дээр шүү дээ. 3 ээлжийн сургуулиуд дээр 45 хүүхдээс дээш байхгүй байх энэ хязгааруудыг бас тавьж байгаа. 1 багшид ноогдох хүүхдийн тоог бууруулъя. Ингээд анги даасан багшийн бас урамшууллын хувь хэмжээг нэмье хүүхдийн тооноос хамаарч.

Хүүхдийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны болон үдийн хоолны илчлэгийг нэмэгдүүлэх ажил байна. Мэргэжлийн боловсрол сургалтын төгсөгчдийг төгсөөд ажлын байртай болгох энэ хувь хэмжээг нэмэх асуудалд бас нэлээн анхаарч ажиллах ёстой. Ингээд их дээд сургуулиудын чанартай их дээд сургуулиудын тогтолцоо руу шилжих ажлуудыг хийнэ. Мөн дэлхийн шилдэг их дээд сургуулиудад суралцуулах боломжуудыг, хүртээмжүүдийг нэмэх ажлууд байна. Салбарын багш, ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгааг хангах шинэ тогтолцоонд шилжих асуудлууд байна. Байгууллагын

хагас бие даасан тогтолцоог төлөвшүүлэх зэрэг бодлогын арга хэмжээнүүдийг дэмжихэд бид нар 24 оны төсвийг чиглүүлсэн болно. Ингээд дээрх шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө Монгол Улсын ЗГ, Монгол Улсын Их Хурал ингээд Байнгын хороодтойгоо хамтарч ажиллах болно.

**Г.Мөнхцэцэг:** Сайдын танилцуулгыг сонслоо. Ингээд хуралдаанд оролцож байгаа асуудалтай холбоотой ажлын хэсгийг хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Цэдэвсүрэн БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга байна. Тамир Дээд боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга, Ариунаа Мэргэжлийн болон техникийн боловсролын газрын дарга Халиунаа, Батцэцэг Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Мягмар СӨБ-ын хэлтсийн дарга, Нансалмаа Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Түмэнжаргал Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Түмэнжаргал. Цолмон Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Итгэл боловсрол, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал, Ганбат Боловсролын үнэлгээний төвийн захирал, Амарбаяр Боловсролын ерөнхий газрын Захиалагчийн хэлтсийн дарга, Цэрмаа Боловсролын ерөнхий газрын ариун цэврийн байгууламжийн төслийн зөвлөх ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Ингээд сайдын мэдээлэлтэй холбоотойгоор асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгье. Баярсайхан гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн асуултаа асууя баярлалаа.

**Т.Аубакир:** Ганц, хоёр асуулт байна. Энх-Амгалан сайдаас энэ хувийн цэцэрлэгүүд саяхан Улаанбаатарт ирээд бас уулзалт хийгээд, Боловсролын яамтай ирээд цаашидаа яаж хамтарч

ажиллах вэ гээд нэлээн том хэмжээний уулзалт болсон. Манай аймгийн хувьд бол 6 хувийн цэцэрлэг аймгийн төв дээр ажилладаг. Энэ маань бас эргээд нэг багишд ноогдох хүүхдийн тоо хэтэрсэн, зарим газар цэцэрлэгийн хүрэлцээ муу байгаа энэ тэртэй холбоотой бас энэ төрийн зарим чиг үүргийг, ачааг бас хуваалцаад үүрэлцээд явдаг л ийм байгууллагууд л даа. Энэ дээр яамны зүгээс яг ямар бодлого баримталж байгаа вэ? Бас л энэ төрийн ачааллыг хуваалцаж байгаагийн хувьд эдгээр цэцэрлэгүүдэд бас ямар дэмжлэг байна вэ? Бид нар Улсын Их Хурлын гишүүний хувьд улсын төсвөөр эдгээр байгууллагуудад бас тоног төхөөрөмж байдаг ч юм уу, зарим нэг зүйл дээр худалдан авалт хийж өгөөд туслаад байж болдоггүй. Яамнаас энэ дээр яг ямар бодлого баримталж байгаа вэ, ямар дэмжлэг үзүүлж байна вэ гэдэг 1 дүгээр асуулт байгаа.

2 дахь асуулт маань улсын төсвөө хэлэлцэж эхэлж байгаа. Энэтэй холбоотой улсын хэмжээнд энэ хуучирч, эвдэрч хэмхэрсэн сургууль, цэцэрлэгүүдийн зарим эд хогшлыг шинэчлэх, шинээр баригдаж ашиглалтад ороход бэлэн болсон сургууль, цэцэрлэгүүдийн хатуу зөөлөн эдлэл, эд хогшлын тал дээр энэ улсын төсөв дээр ер нь бас ахиухан хөрөнгө мөнгө шийдвэрлүүлж чадсан болов уу? Манай аймгийн хувьд бол Боловсролын газраас бид нар судалгаа авхуулаад бүх сумдууд дээр, аймгийн төвүүд дээр ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгүүдээс судалгаа авхуулсан. Үндсэндээ манай аймаг дээр л гэхэд жишээлбэл 2,5 тэрбум төгрөгийн эд хогшлыг шинэчлэх, шинээр худалдаж авах ийм шаардлага үүсэж байгаа. Энэ дээр улсын төсөв дээр бас ямар арга хэмжээ авч байгаа вэ гэж.

3 дахь асуулт маань Цэдэвсүрэн даргаас нэг асуулт байгаа. Та 21 оны 11 сарын 29-ний өдөр энэ боловсролын судалгааны Үндэсний Хүрээлэнгийн хүрээлэн дээр судлагдахуун ба хэлийг

интеграцилан суралцахуйг нэвтрүүлэх гээд энэ нэлээн дажгүй ажил хийчихсэн байгаа. Энэ маань эргээд хос хэлний хөтөлбөрийг дэмжих судлах, тэрэнд судалгааны түвшинд хэрэглэгдэхүүн сурах бичиг энэ тэрээр хангах асуудлуудын бас нэг чиг баримжаатай болсон байх гэж бодож байна. Энэ маань энэ хос хэлний хөтөлбөр батлагдсантай холбоотой, өөр хэл бүхий үндэстнүүд маань манай Тува хэлтэй хүүхдүүд байна, Казах хэлтэй хүүхдүүд байна эх хэл дээрээ боловсрол эзэмшдэг, энэ боловсрол эзэмших явцад энэ хүүхдүүдийг сурах бичиг хэрэглэгдэхүүнээр хангах бололцоо бүрдлээ гэж би харж байгаа юм. Тийм учраас мөн энэ улсын төсөвтэй холбоотой эдгээр өөр хэл бүхий хүүхдүүдийн ном сурах бичгийн асуудал шийдэгдэж байгаа юу гэсэн 3 дахь асуулт маань Цэдэвсүрэн даргаас асууж байгаа.

Сайдаа бас бас энэ яах вэ сүүлийн үед энэ нэг сошиал дээр бас нэг манай аймагтай холбоотой нэг 1 цэцэрлэг 12 ч билүү, 14 ч билүү сахиул манаачтай байсан юм байна гэдэг дээр нэг та эцсийн байдлаар нэг хариулт өгчхөөч. Энэ маань эргээд бас нэг аймгийг шуугиулчихсан, тэрийг нь шүүрч аваад зарим нэг нөхдүүд нэг тайлбар нэхсэн live хийсэн нэг ийм шоу маягтай болчихлоо даргаа. Хүн бол яах вэ дээ ярианы явцад нэг элдэв алдаа бол гарч л байдаг, нэг их том асуудал болгоод байхгүй байна миний хувьд бол зүгээр. Та энэ дээр нэг эцсийн байдлаар нэг хариулт өгчих үү гэсэн ийм асуултууд байна.

**Г.Мөнхцэцэг:** Аубакир гишүүний асуултад Энх-Амгалан сайд. Баян-Өлгий аймагт болоод байгаа үйл явдалтай холбоотой, төсөвтэй холбоотой асуудлаар хариулт өгье.

**Л.Энх-Амгалан:** Бид нар энэ хөдөө орон нутагт байгаа цэцэрлэгүүдийнхээ асуудлуудыг бас нэг түр энэ эргэж харж, ер нь өнгөрсөн

хугацаанд энэ цэцэрлэгийн хүртээмжийг бий болгоход, энэ хувийн цэцэрлэгүүдийн гүйцэтгэсэн үүрэг ролиуд маш их байгаа. Тэгэхээр ингээд яг Монгол Улсад үүсчихсэн байгаа энэ хувийн цэцэрлэгүүдийнхээ тогтолцоог ингээд төр өөрөө ингээд яачхаж болохгүй л дээ, орон зайг нь хаачхаж болохгүй л дээ. Төр дангаараа ингээд цэцэрлэгийн хүртээмжийг шийднэ гээд ингэж явж болохгүй. Бид нар нийслэл дээр ч гэсэн энэ цэцэрлэгийн хүртээмжийг шийдэхэд төр хувийн хэвшлийн түншлэлээр хамтарч ажиллаж байж тодорхой үр дүнд хүрсэн. Хамгийн гол асуудал бол энэ аймгийн төвүүд дээр байгаа хувийн цэцэрлэгүүд дээр асуудал үүсээд байгаа юм байна лээ. Тэгээд би өнгөрсөн долоо хоногт биш ээ, энэ долоо хоногт энэ хөдөө орон нутагт байгаа бүх хувийн цэцэрлэгүүдийн төлөөллүүд, үүсгэн байгуулагч нарыг дуудаж уулзаж бас бид нар нэлээн уулзалт зөвлөгөөнүүдийг хийж, цаашидаа ер нь төр энэ хувийн хэвшлийн цэцэрлэгүүдтэйгээ яаж хөдөө орон нутаг дээр яаж хамтарч ажиллах юм бэ, хамтын ажиллагааны ямар хэлбэрүүд байх юм бэ гэдгээ бас нэлээн сайн ярилцсан. Орон зай байна уу байхгүй юу гэдэг асуудлууд.

Тэгэхээр үндсэндээ бол нийт СӨБ-ын насыг бид нар энэ шинэ хуулиар нэг насаар доошлуулж, 2 нас болгосон учраас ерөнхийдөө цаашидаа хөдөө орон нутаг дээр энэ өмнө нь байж байгаа байсан яслийн тогтолцоо гэж ярьдаг шүү дээ бид нар тийм ээ. Энэ яслийн тогтолцоог сэргээх бас ийм хэрэгцээ шаардлагууд үүсэж байгаа юм байна лээ. Тэгэхээр энэ орон зай үүсвэл энэ юу хувийн цэцэрлэгүүдийг бас бид нар энэ орон зай руу нэлээн оруулъя, 2 настай хүүхдүүдийн хүртээмж дээр бас хамтарч ажиллая.

2 дугаарт нь бол энэ Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн бид нар нэг өөрчилж шинэчилж гэдгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай ярьж байгаа. Тэгээд энэ хүрэн дээр бас энэ

хувийн цэцэрлэгүүдийн хамтын ажиллагааг энэ хүрээнд бас нэлээн хамтарч ажиллах шинэ хэлбэрүүдийг бас гаргая гэж бид нар ярилцсан.

3 дугаар асуудал бол энэ хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийг энэ цэцэрлэгт хамруулах асуудал дээр бас хувийн цэцэрлэгүүдийн санал санаачилгууд хувийн цэцэрлэгүүд дээр байгаа энэ боломжуудыг бас ашиглаж ажиллая гэдэг нэг ийм 3 чиглэлээр бид нар үйл ажиллагааныхаа замын зураглал гэдэг юм уу энийг тодорхойлсон гэж хэлж болно. Саяын хийсэн уулзалтаас бас гарсан нэг үр дүн бол энэ хувийн цэцэрлэгүүд дээр өгч байгаа хувьсах зардлын чинь 77 хувь байх, би андуураагүй бол 77 хувь нь төр санхүүжүүлдэг, 26, 27 хувийг нь бол үүсгэн байгуулагч санхүүжүүлдэг. Тэгэхээр бид нар энэ төрөөс санхүүжүүлж байгаа энэ 77 хувийг 2 дахин үржүүлж 1,2-оос 1,4 сая төгрөгт болгож бид нар энэ тарифаа нэмж, хөдөө орон нутаг дээр байгаа цэцэрлэгийн хүртээмжийн асуудлаа шийдвэрлэе гэдэг энэ тогтолцоонд хүрсэн байгаа Аубакир гишүүнээ.

2 дугаар асуудал бол ерөнхийдөө энэ шинээр орж байгаа цэцэрлэг, сургуулиудын хангамжийн асуудлууд, ширээ сандлууд, компьютер тоног төхөөрөмжийн асуудлууд лабораториудын асуудлуудыг яам шийднэ. Энэ дээр бол бид нар бодлого барьж ажиллана. Гэхдээ орон нутаг бас тодорхой шинэ хуулиар бас тодорхой хариуцлагуудыг хүлээдэг болсон. Бүгдийг яам шийдэхгүй. Энэ бол сум, аймаг, нийслэлийн иргэдийн Хурлаас бол тодорхой засвартай холбоотой, тодорхой тоног төхөөрөмжийн хангалттай холбоотой асуудлуудыг бол аймаг, орон нутгийн төсвийн эх үүсвэрээр бид нар хамтарч шийдэх бас ийм эрх зүйн зохицуулалтуудтай болсон байгаа. Нөгөө талаасаа бол бид нар энэ хувьсах зардлынхаа аргачлалд бид нар өөрчлөлт хийж, энэ нөхөн хангалтын



зардлуудыг олгодог болсон. Цэцэрлэг дээр ч олгодог болсон, сургууль дээр ч олгодог болсон. Хүүхдийн тооноос шалтгаалж. Энэ энэ санхүүжилт бол их багагүй санхүүжилт бас очиж байгаа. Энэ санхүүжилтийн эх үүсвэрээр бол цэцэрлэг, сургууль бол өөрсдөө шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийнхөө асуудлуудыг шийдэх ийм боломжууд, шинэ боломжууд гарч байгаа гэж ойлгож болно.

Нөгөө Улсын Их Хурлаар батлагдсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль энэ I сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ. Тэгэхээр энэ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хуулийн хүрээнд бол бид нар сургуулийнхаа интернэтийн асуудлуудыг wi-fi сүлжээнд шилжүүлэх асуудлыг бид нар хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч 3 жилийн дотор энэ.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдын микрофоныг нэмж 1 минут нэмчихье.

**Л.Энх-Амгалан:** Санхүүгийн түрээс хэлбэрээр энэ шинэ хэлбэрүүдийг гаргаж ирж байгаа. Цаашидаа бид нар энэ амархан элэгддэг энэ сургууль, цэцэрлэг дотуур байран дээр элэгддэг энэ юунуудыг ч гэсэн ингээд тодорхой ийм Төр, хувийн хэвшлийн түншлэлээр шийдэх ийм зөв шийдэл байх болов уу гэж бас харж байгаа.

Баян-Өлгий аймаг дээр үүссэн нөхцөл байдал бол тодорхой ганц нэг тоонууд дээр ийм алдаа гарсан гэдгийг бас би хэлчихье. Ингээд уучлалт бас гуйж байна. Нөгөө талаасаа бол Баян-Өлгий дээр асуудал бол их байгаа. Өнөөдөр нийт аймгийн хэмжээнд бол би дахиад андуураагүй бол Ням-Очир 400 тийм ээ, 400 орчим нэмж илүү орон тооны илүүдэлтэй байсан аймаг. Өнгөрсөн 2 жил бол би Баян-Өлгий аймгийн энэ боловсролын чанарыг бас шинэ шатанд гаргахын тулд Улаанбаатар хотоос 30-аас 40 хүнтэй гавьяат багш нарын

багуудыг томилж ажиллуулж байгаа. Энэ бол маш том үр дүн өгч байгаа. Манай бас хэд хэдэн бид нар зөвлөн туслах үйл ажиллагааг нэлээн өгч байгаа. Энэ чиглэлээр бол манай Баян-Өлгийн цэцэрлэгийн сургуулиуд.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Тэр тийм хос хэлний сургалтын хөтөлбөртэй холбоотой, сурах бичгийн хүртээмжтэй холбоотойгоор Цэдэвсүрэн даргаас асуулт асуусан. Энэ асуултад Цэдэвсүрэн дарга хариулъя.

**Л.Цэдэвсүрэн:** Гишүүний асуултад хариулъя. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд бид судлагдахуун ба хэлийг интеграцилан суралцахуй арга зүйг Баян-Өлгий аймгийн зарим сургуулиуд дээр туршиж, үүнийхээ үр дүнд суурилсан хос хэл сургалтын талаар баримтлах чиглэлийн төслийг боловсруулаад ингээд явж байна. Төсөл маань дууссан учраас энэ арга хэмжээг цаашид бол Боловсролын ерөнхий газар болон хүрээлэн ингээд цааш нь аваад явна. Мэдээж энэ дээрээ суурилсан сурах бичигтэй холбоотой асуудлууд бол үүсэж байгаа. Тухайлбал энэ хос хэлтэй холбоотой асуудлыг бид нар Баян-Өлгий аймаг дээр буюу бусад нөгөө Тува өөр хэл дээр 4 дүгээр ангиас нь эхлээд зарим хичээлийг хос хэлээр зохион байгуулахаар төлөвлөөд явж байна. Тухайн хичээлд ашиглах эх хэл болон Монгол хэлний харьцаа эх хэл нь 80-аас 70 хувь Монгол хэл нь 20-оос 30 хувь байх гэх мэтчилний ингээд тооцоолуудыг хийсэн.

Боловсролын ерөнхий хууль болон дагалдан гарах батлагдах хуулиудыг хүлээгээд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалын төсөлтэй бас хос хэлний сургалтын талаар баримтлах чиглэлийг тусгахаар ингээд боловсруулаад дууссан байгаа хүрээлэнгээс. Үүнийг Боловсролын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлээд ЗГ-ын



хуралдаанаар батална. Сурах бичигтэй холбоотой асуудал дээр 2024 онд сурах бичгийн түрээс дээр 6,4 тэрбум, ер нь сурах бичгийн нийт хангалт дээр 4,3 тэрбум төсөв төсөвлөөд Их Хуралд өргөн барьчихсан байгаа. Тэгээд энэ маань бол батлагдах юм бол энэ дотор хос хэлний сургалттай холбоотой сурах бичгийн асуудлууд давхар шийдэгдээд явагдана. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Ц.Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр Улсын Их Хурлын хаврын чуулганаар Монголын боловсролын салбарын гол хуулиудыг баталж, тэр хуулийн хэрэгжилт маань ингээд салбарын яам нь эхнээс нь амжилттай хэрэгжүүлээд явж байгаад бас баяр хүргэе. Өчигдөр ингээд анх удаагаа Монгол Улсын Их сургуулиудын эрэмбийг олон улсын үнэлгээний бодлоготой хамтран гаргасныгаа олон нийтэд зарлалаа. Энэ бол үнэхээр бас олны анхаарал татсан их томоохон ажил болж байна. Дээд боловсролын тухай хуульд тодорхой заалтуудын дагуу 2 жил тутам энэ үнэлгээний байгууллагууд энэ их дээд сургуулийн эрэмбийг тогтоох ёстой. Энэ маань манай боловсролын шинэчлэлд их томоохон хувь нэмэр оруулна. Бид нар өөрсдөө яг хаана явж байна, их сургуулиудын эрэмбэ юу нь олон улстай ямар харьцуулахад ямар байна гэдгээ бид өөрсдөө харах их томоохон боломж байна. Энэ чиглэлээр тэгээд эцэг эхчүүд, манай эрдэмтэд бол ихээхэн саналаа ирүүлж байна.

Ингээд энэ эрэмбийн маань энэ 4 гол үзүүлэлт бол үнэхээр бас чухал үзүүлэлтүүд байгаад байна. Сургалт, эрдэм шинжилгээ, гадаад харилцаа, орчин гээд. Тэгээд мэдээж манай төрийн өмчийн 6 их сургууль бол энийг эрэмбийг бол тэргүүлж байгаа, энэ бол ойлгомжтой. Яг энэ их сургууль гэдэг нэр статус доор байгаа 61 их сургууль энд бол орсон байгаа. Тэгээд яг эрэмбийн

ингээд юуг ингээд задлан харахаар зарим их сургуулиуд нь бараг их сургууль байтугай, дээд боловсролын байгууллага гэж нэрлэхэд ичмээр тийм үзүүлэлттэй байгаа шүү дээ. Ер нь бол олон улсын жишигээр их сургууль гэдэг бол сургалт эрдэм шинжилгээ аль аль нь зэрэг явах ёстой, их сургуулийн багш нар бол эрдэмтэд ахисан түвшний судалгаа хийдэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, судалгаа шинжилгээ, олон улсын бүтээлд өгүүллээ хэвлүүлдэг ийм эрдэмтэд байх ёстой. Тэгэхээр энэ үнэлгээнээс гарсан нь ямар ажлууд хийх вэ гэдгийг энэ Дээд боловсролын газар болон яамнаас асуумаар байна.

Ер нь ингээд харахад бол энэ 60-аас доош үнэлгээ авчихсан их олон их сургуулиуд байна. Энийг бол яаралтай тэр коллеж ангилалд нь оруулах зэрэг захиргааны арга хэмжээ авах нь зүйтэй байна. Эсвэл яг энэ эрэмбээр тодорхой босго тавиад энэ 60 байна уу, 50-иас дээш хувийг нь хангахгүй байгаа их сургуулиудад олох төрийн дэмжлэг эсвэл тухайн сургуулиудын оюутнууд тэтгэлэг зээл авах гэдэг юм уу эдгээрийг нь хязгаарлавал яасан юм бэ? Ингээж байж бид нар энэ олны маань хүсэн хүлээгээд байгаа чанаргүй их сургуулиудыг цэгцлэх ажил маань хийгдэнэ. Тэгэхээр энэ эрэмбийн араас яг яаралтай ямар арга хэмжээ авах вэ гэдгийг асуумаар байна.

2 дугаарт нь энэ тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсролын талаар манайд Боловсролын ерөнхий хууль, Боловсролын багц хуулиуд дахь яг ямар заалтуудыг хэрэгжүүлж байгаа вэ? Ер нь бол энэ манай дунд болон СӨБ, мэргэжлийн боловсрол зэрэг дээр бол тусгай хэрэгцээт хүүхдүүд маань яг 100 хувь бол сургалтад хамрагдаж чадахгүй байгаад байгаа. Зүгээр надад байгаа мэдээллээр бол ерөнхийдөө цэцэрлэгийн насны хүүхдүүдийн маань 63 хувь нь бол боловсролд хамрагдсан, СӨБ-ын боловсролын үйлчилгээ авч байна, цэцэрлэгт явж байна. 6-аас 17 насны хүүхдүүдийн 70 орчим хувь нь

боловсролын үйлчилгээ аваад, ер нь 30-аас 40 орчим хувь нь бол яг энэ сургуульд тэгш хамрагдаж чадахгүй байгаад байна. Тэгэхээр ер нь боловсролыг тэгш хүртээмжтэй болгох чиглэлээр яг яам болон манай Боловсрол ерөнхий боловсролын газар ямар ажил хийж байна вэ?

Энэ чиглэлээр бол манай МУБИС-д 2015 оноос тусгай хэрэгцээт боловсролын багшийн анги нээгээд 3,5 жилээр бакалаврын мэргэжилтэн бэлтгэж байгаа. Тэд нарт үзүүлэх дэмжлэг маань ямаршуу байна? Ер нь бол эрт оношлох аутизм болон дауны эмгэгтэй хүүхдүүдийг оношлох ажлууд маань хэр явагдаж байна вэ? Энэ чиглэлээр бол ажиллах мэргэжилтнүүдийг бэлтгэх, дээрээс нь ялангуяа яг энэ тусгай хэрэгцээт чиглэлээр ажиллаж байгаа багш нарын цалин хангамжийг үнэлэх энэ систем дээр ямаршуу дэвшил гарч байна гэдгийг тодруулж асуумаар байна яамнаас.

**Г.Мөнхцэцэг:** Мөнхцэцэг гишүүн, Мөнхцэцэг гишүүн нэлээн хэд хэдэн асуулт асуучихлаа. Энх-Амгалан сайд эхнээс нь хариулаад, 2 асуултад нь Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ Боловсролын багц хуулийн дотор Дээд боловсролын хууль дээр манай Дамдинням гишүүн ерөнхийдөө энэ нэг ийм олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудаар эрэмбэ бол, эрэмбэ хийдэг болъё, 2 жил тутам гэж энэ заалтыг оруулсан. Энэ бол дээд боловсролын чанарын үзүүлэлтэд маш том дэвшил болох маш том хөшүүрэг болох энэ заалтууд хийсэн. Тэгээд бид нар энэ нэгэнт хууль батлагдсан учраас хуулийнхаа хэрэгжүүлж эхлэх хугацааг хүлээхгүйгээр энэ 5 сард бид нар бас энэ Английн Times high education энийг л бид нар баримталдаг шүү дээ угаасаа тийм ээ. Шилдэг зуун их дээд сургуулиуд хүүхэд явуулна гэхэд бид нар энэ жагсаалтыг л хардаг. Тэгэхээр Английн Times high education-тай хамтарч арга зүйн

зөвлөгөө авч бид нар урьдчилсан юу зарлаж байгаа юм, урьдчилсан эрэмбэ зарлаж байгаа юм. Яагаад би урьдчилсан гэж хэлж байна вэ гэхээр яг албан ёсны эрэмбүүд нь бол ирэх хавар зарлагдана, бүтэн жилийн ажил болж байгаа.

Гэхдээ ямар ч байсан энэ дээр тийм маргаан гарахгүй болов уу гэж бодож байна. Яагаад гэвэл өөрөө бид нар энэ үнэлгээний бүх дата, бүх судалгаа, бүх тооцоо бүх юунуудаа энэ Times high education дээр манай Боловсролын үнэлгээний төв нэлээн голлох үүрэг роль оролцож, энэ үнэлгээнүүд, урьдчилсан үнэлгээнүүд хийгдсэн учраас ирэх хаврын үнэлгээ бол би нэг энэнээс нэг их зөрөхгүй болов уу гэж бодож байна.

Тэгээд одоо бид нар байгаа байдал дээр л харах ёстой. Бид нарын байдал л ийм байна. Өнөөдөр их сургууль гэдэг статус авчхаад, тэгээд хөтөлбөр нь заах багшгүй оюутнуудтай. Саяхан хүртэл айлын орон сууцын подвалд хүртэл байгаа их дээд сургуулиуд байсан шүү дээ. Өнгөрсөн нэг жил бол бид нар 27 их дээд сургуулиудын үйл ажиллагааг бид нар цуцалсан. Одоо цаашидаа их сургууль нь их сургууль шиг тийм ээ, коллеж нь коллеж шиг л байх ёстой л гэж би ойлгож байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар нөгөө 60 чавганц хуралдвал 101 нь нэг, зуун чавганц хуралдахад нэг нь түрүүлнэ гэдэг шиг Монголын нөхцөл байдал нэг ийм л байгаа юм. Энэ дээр тийм эмзэглээд, өөнтөглөөд, хөндлөнгийн нөлөө орлоо гээд ингээд байх ерөөсөө шалтгаан байхгүй.

Одоо би Times high education Монголын нэг их цөөн их дээд сургуулиудын нөлөөнд автаж ийм эрэмбэ гаргаж байна гэж би бодохгүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ бол яах вэ санаатай нэг энэ эрэмбийг гуйвуулах гэсэн, энэ ач холбогдлыг бүдгэрүүлэх гэсэн ийм л зүйл болов уу гэж бодож байна. Тэгээд бид нар хаана байгаагаа ингээд нэг харчих хэрэгтэй. Гацуун ч гэсэн үнэн. Тэгэхээр өнөөдөр яг үнэнийг хэлэхэд та саяын

өчигдрийн эрэмбийг харахад бол үндсэндээ сургалтынх нь чанар нь дөнгөж 50 хувийн босго дамжиж байгаа 28-хан сургууль байгаа шүү дээ. Тэгээд цаашидаа бол ер нь Монголд бол би нэг 20 их сургууль л байх юм байна даа л гэж харж байгаа. Бусад нь бол тэгээд коллежоороо үйл ажиллагаагаа хийнэ биз. Заавал ч үгүй өнөөдөр дээд боловсролын диплом өвөртөлчөөд, тэгээд ингээд ажилгүйдлийн эгнээнд өнөөдөр яг Монгол Улсад идэвхтэй ажил хийж байгаа 20 мянган идэвхтэй ажил хийж байгаа, ажилгүй 110 мянган хүн байгаа шүү дээ. Идэвхтэй ажил хийж байгаа 20 мянган залуучуудын 3 хүний 1 нь дээд боловсрол өвөртөлчөөд, ажлын байр олж чадахгүй, ажлын байран дээр очоод ур чадвар нь хангаж чадахгүй байна гэдэг бол манай бол дээд боловсролын тогтолцоо, мэргэжлийн боловсролын тогтолцоо хаана байна вэ гэдгээ л бид нар харж байгаа юм. Тэгэхээр энэ алдаа дутагдлуудыг бид нар засах ёстой.

Энэ эрэмбийн дараа та яг юу хийх вэ гээд байх шиг байна. Эрэмбийн дараа бид нар яг дээд боловсролын мэргэжлийн боловсролынхоо яг хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт, нийлүүлэлт дээр байгаа тэр тусмаа ур чадварын эрэлт, нийлүүлэлт дээр шаардлагатай байгаа энэ хөтөлбөрийн шинэчлэлүүдийг хийх ёстой л гэж би харж байгаа. Тэгээд өнгөрсөн жил бид нар чинь 4000 гаруй хөтөлбөрүүд байсан, энэ хөтөлбөрүүдийн давхцалуудыг арилгаж бараг үндсэндээ 2300 орчим хөтөлбөрүүдийг бид нар яачихсан шүү дээ цаг үеэсээ хоцрогдчихсон ингээд ийм хөтөлбөрүүдийг бид нар бас хаасан байгаа. Тэгээд цаашидаа бол бид нар энэ чиглэл рүү яг боловсролын салбарын шинэчлэл бол яг энэ эрэмбэд байж байгаа.

Цаашидаа бол их сургууль ганцхан оюутныхаа тоогоор өрсөлддөг эсхүл үнээ, сургалтынхаа хөтөлбөрийг юу сургалтынхаа төлбөрийг бууруулж

өрсөлддөг ийм байж болохгүй. Энэ бол цаашиаа яг *teaching university, research university* буюу сургалтын судалгааны тэгээд.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Тэр эрэмбээс доогуур оноо авсан тийм ээ, 60-аас доош оноо авсан энэ сургуулиудыг цаашид яах юм бэ, энэ дээр ямар арга хэм хэмжээ авах юм бэ гээд нэлээн асуулт, хариулт шаардсан ийм асуулт асуучих шиг болсон. Дээрээс нь дахиад тэр тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсрол сургалтын чиглэлээр асуулт асуусан энийг Тамир дарга хариулах юм уу? Энх-Амгалан сайд нэмж хариулья. Энх-Амгалан сайдын 5 минутыг нь нэмээд өгчихье.

**Л.Энх-Амгалан:** Ийм ажлуудыг хийн. Тэгээд ер нь цаашидаа бол бид нар энэ эрэмбэ зарлаж байгаагийн гол юу бол үндэслэл бол ер нь бид нар сая тэргүүлэх эрэлттэй мэргэжлүүдийн жагсаалтыг Монгол улсын ЗГ баталсан. Тэгээд цаашидаа бол энэ их дээд сургуулиуд бол яг Монгол Улсын хөгжил дэвшилд хэрэгцээтэй байгаа энэ мэргэжлээр залуучуудыг сургадаг, эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр сургадаг ийм тогтолцоо руу шилжих ёстой. Ингэвэл бид нар боловсролын зээлийн сангаас энэ өндөр эрэмбэд байгаа сургуулиудын оюутнууд энэ Боловсролын зээлийн сангаас тэтгэлэг авах ийм боломжууд өндөр эрэмбэд орсон төрийн өмчийн их дээд сургуулиуд төрийн дэмжлэгүүдийг авах ийм боломжууд нээгдэж байгаа. Өчигдөр бас бид нар эрэмбэ зарласантай холбогдуулж Монгол Улсад анх удаа 1, 2, 3 дугаар эрэмбээр эрэмбэлэгдсэн МУИС, Анагаах ухааны Үндэсний их сургууль, Шинжлэх ухаан, технологийн үндэсний их сургуулийн докторантыг бид нар 20 докторантыг цалинтай докторантурын хөтөлбөр зааж зарлаж байгаа. Ингэж байж л бид нар боловсрол дээр дээд боловсрол дээр энэ чанарын өөрчлөлтүүд гарах болов уу гэж ингэж харж байна.

*Ер нь бол тэгээд бараг 50-иас доош хувийн сургалтын чанар үзүүлж байгаа энэ сургуулиуд үйл ажиллагаа явуулахад хүнд. Тийм учраас яамнаас бол маш тодорхой бодлогууд авч хэрэгжүүлнэ. Ингээд цаашидаа бол зарим сургуулиудын үйл ажиллагааг бид нар зогсоох, зарим сургуулиудыг бол коллеж хэлбэрээр ангиллуудыг доош нь бууруулах ийм ажлуудыг л авч хэрэгжүүлэх болов уу гэж харж байгаа.*

*Тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн асуудал дээр бид нар энэ тэгш хамран сургах эрх зүйн шинэчлэлийг бид нар хийсэн. Манай Боловсролын хуулийн хамгийн том эрх зүйн шинэчлэлийн нэг бол энэ тэгш хамран сургах асуудал, эрх зүйн шинэчлэл байгаа. Энэ хүрээндээ бид нар одоо байгаа Монгол Улсад байгаа тусгай хэрэгцээтэй шаардлагатай байгаа хүүхдүүдийг энэ боловсролыг бид нар яаж олгох вэ гэдэг асуудал дээр бас нэлээн ийм бодлогын шийдлүүд гаргаж ажиллаж байна. Хуулиар эрх зүйн орчинтой болох нэг өөр, яг бодитойгоор өнөөдөр таны хэлж байгаагаар СӨБ-ын тэр цэцэрлэгийн гадна үлдэж байгаа 30 хувь, ЕБС-н түвшинд цэцэрлэгийн юу сургуулийн гадна үлдэж байгаа 40 хувь дээр яаж энэ боловсролын үйлчилгээг хүргэх вэ гэдгийг бид нар тодорхой шийдлүүд гаргаж байна.*

*Өнгөрсөн долоо хоногт би бас энэ Монгол Улсад байгаа Улаанбаатар хотод байгаа нийт 6 тусгай сургууль, 2 цэцэрлэгээр очиж ажилласан. Ер нь бол бид нарт маш их туршлага байгаа юм байна. Бид нар нөгөө айлаас ирэхээр авдраа ухаг гэдэг шиг 63 дугаар сургууль, ингээд энэ 55 дугаар сургуулиуд дээр бол яг жинхэнэ утгаар нь бид нарын энэ хууль дээр заасан байгаа дэмжих төв тийм ээ цогц үйлчилгээг авах энэ боломжууд өнөөдөр Монгол Улсад бий болчихсон байна. Тийм учраас цаашидаа бид нар ерөнхий мэдээж дунд болон урт хугацаанд бол аль болохоор ерөнхий боловсролын энгийн сургуульд хүүхдүүдийг шилжүүлэх бид нар бодлого*

*барина. Гэхдээ бид нар амьдрал дээр яг бодитойгоор харах ёстой юм байна лээ. Ер нь бол хүнд хэлбэрийн ийм хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бол заавал ч үгүй энэ тусгай сургууль, цэцэрлэгүүдээр дамжиж байж хамгийн бага боловсролоо олж байж тэр тэгш нөгөө бүх бас хөдөлгөөн засал гэдэг юм уу тийм ээ, хэл засал гэдэг юм уу энэ бүх шаардлагатай байгаа тэр үйлчилгээнүүдээ авч байж бас тодорхой дэмжих төвүүдийн үйлчилгээнүүдээ авч байж цаашаа дараагийн шатлан суралцах энэ боломжуудыг бид нар хангах ёстой юм байна гэж харж байгаа.*

*Ер нь бол яг надад төрсөн итгэл үнэмшил бол бид нар өнөөдөр Монгол Улсад бий болчихсон байгаа энэ 63 дугаар сургууль, 52 дугаар сургуулийнхаа юун дээр туршлага дээр үндэслэж, энэ 2 сургуулийг ер нь үндэсний хэмжээний түшиц сургууль болгож зарлая гэж байгаа юм. Тэгээд энэ сургуулиуд дээр тэр ЕБС дээр, жирийн сургууль дээр шилжиж очиж байгаа хүүхдүүд дээр ажиллах гэж байгаа багш нарыг давтан сургах асуудлууд тийм ээ, арга зүйн дэмжлэг үзүүлэх асуудлууд дээр ингээж суурилж ажиллах нь зүйтэй юм байна. Ингээж чадах юм бол бид нар өнөөдрийн байгаа тэгш хамран сургуулах сургах энэ хувь хэмжээг бол өсгөх ийм боломжтой байгаа.*

*Одоо хамгийн гол зүйл бол ерөөсөө л эрт оношилгоо. Тийм учраас бид нар энэ 3 сайдын хамтарсан тушаалууд дээр тушаалуудыг шинэчилж ажиллаж байгаа. Сар тутам, зарим 2 сар тутамд 3 сайд Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайдын уулзалтуудыг бас энэ хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээтэй хүүхдүүдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээг яаж сайжруулах вэ чиглэлээр бид нар бас ярилцаж тодорхой шийдлүүд бас гаргаж байгаа. Ингээд ер нь бол тэр яг эхээс төрж байгаа хүүхдүүдээс нэг тодорхой урьдчилсан байдлаар нөгөө эрт*



илрүүлгийн шинжилгээнүүдийг авч чадах юм бол бид нар их том дэвшил гаргаж чадах юм байна лээ. Жилд 3,2 тэрбум төгрөг байх юм бол нийт 70-аас 80 мянган төрж байгаа эхчүүдээс бид нар цаг хугацаа алдахгүйгээр энэ шинжилгээнүүдийг авчихад бол нийт эрсдэлд орох хүүхдийн 40 хувийнх нь, бараг 60 хувийнх нь ирээдүйг хамгаалж чадах ийм том боломжууд байгаа гэж харж байгаа. Энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хороотой, өөрийнхөө Байнгын хороотой хамтарч энэ ЭМД-ын сангаас энэ 3,2 тэрбум төгрөгийн асуудлыг шийдэж чадах юм бол энэ дээр бол маш том дэвшилүүд гарна гэж бодож байгаа. Ер нь цаашидаа бид нар энэ эрт оношилгоо, эрт оролцоог бид нар шинэ шатан дээр гаргаж байж л энэ тусгай хэрэгцээ буюу хамран сургах, тэгш хамран сургах энэ тогтолцоог Монгол Улсын хөрсөн дээр буух ёстой л гэж харж байна.

**Г.Мөнхцэцэг:** Баярлалаа.  
Баярсайхан гишүүн асуултаа асууя.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Юуны өмнө энэ их дээд боловсролын чанарын асуудал, их дээд сургуулиудын үр дүнтэй хүний нөөц бэлтгэх асуудал дээр бол яахын аргагүй түүхэндээ бол Энх-Амгалан сайд хамгийн их ийм шигшилт хийсэн сайд бол мөн. Намайг энэ яаманд ТНБД-аар ажиллаж байхад тухайн үед 118 их дээд сургуультай байсан. Энийг бол зүгээр лиценз цуцлаад яваад байдаг юм биш, энэ бол маш их тэмцэл, маш их хүчтэй ингэж тулдаг ийм ажил юм. Тэгэхээр энэ ажилд бол талархаж байгаа гэдгээ 1 дүгээрт хэлье. Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын асуудал дээр яах вэ хотод бол ингээд Нийслэлд бол цэцэрлэгийн хүртээмж юу эд нар бол ингээд бас дажгүй яваад байна. Хөдөө орон нутагт ялангуяа энэ алслагдсан аймаг, Завхан аймагт жишээлбэл өнөөдрийн байдлаар Идэр, Эрдэнэхайрхан сумын сургууль, Улиастай сумын 2 дугаар сургуулийн

спорт заал, Тосонцэнгэл, Баянхайрхан сумын цэцэрлэгийн барилга үнийн өсөлтөөс шалтгаалаад ингээд гацчихсан байж байна.

Тэгээд яг энэ асуудлаас болоод зөвхөн барилгын асуудал биш цаад талд нь хүний, хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхдийн сурч боловсрох эрх, аюулгүй орчинд байх эрх гээд өчнөөн олон зүйл ингээд зөрчигдөж байна. Түрүүний Энх-Амгалан сайдын хэлсэн тендерт бага үнээр ороод, ингээд тэр Барилгын хөгжлийн төвөөр магадлал гэж нэг юм хийлгээд, ингээд энэ улсын тендерт жил болгон бараг шантаажлаад ингээд мөнгө нэмүүлж байдаг бол барилгууд байдаг. Тийм учраас та энэ миний дурдсан энэ сургууль, цэцэрлэгийн барилгууд дээр энэ яамныхан байж байна онцгой анхаарч, энэ үнэхээр үнийн өсөлт нь байна уу, ямар байна вэ энэ дээр сайдын хувьд бас анхаарч өгөөч гэж танаас хүсэж байна. Тэгээд энэ дээр бас мэдээлэлтэй байвал яам бас хариулж өгөөрэй гэж хүсэж байна.

2 дугаарт өмнөх жилүүдэд би 3 жил бас ярьж байна. Үндэсний Аудитын газраар 16 сумд аудитын дүгнэлт хийлгэхэд Завхан аймагт хийгдсэн бүх сургууль, цэцэрлэг, дотуур байрны мөн манай Боловсролын яам соёлыг хариуцдаг байхад спорт, соёлын барилгууд бол бүгд чанаргүй. Тэгээд энэ орон нутгийн асуудал юм шиг үлдэж байгаа боловч, салбарын сайдын хувьд та тэнд байгаа хүүхдүүдийн эрх бас зөрчигдсөн хэвээрээ байгаа гэдэг дээр санаа тавьж, энэ салбарын сайдын хувьд тэр хүүхдүүдийг дулаан, мөөгөнцөргүй, хөлдүү биш, дулаахан ийм тохилог орчинд сургахын төлөө энэ хариуцлага алдсан хүмүүст нь бас хариуцлага тооцуулах тал дээр ядаж албан бичиг өгч дуу хоолой болж өгөөч гэж бас танаас хүсэж байна. Энэ бол аудитын дүгнэлт гарчихсан асуудал байгаа.

3 дугаарт энэ Ням-Очир дарга манай ус, ариун цэврийн байгууламжийн



ажлын хэсэг ороод ирчихсэн байгаа юм чинь яг өнөөдрийн байдлаар ус, ариун цэврийн байгууламж хөдөө орон нутагт ямар үр дүнтэй хэрэгжиж байна вэ? Хэдэн сургууль, цэцэрлэг, дотуур байр модон жорлонгоосоо гүйцэд салсан бэ, чанарын асуудал ямар түвшинд явж байна вэ? Энэ дээр нэг Ням-Очир даргаас мэдээлэл авъя гэж бодож байна.

4 дүгээрт нь энэ Боловсролын багц хууль батлагдсантай холбоотой бид нар өнөөдөр хамгийн их алдагдсан энэ хүмүүжил, хүүхдээ зөв сайн хүн болгох энэ дээр бид нар зорилго тавьчихсан. Хүүхдээ сайн хүн болгоно гээд. Энэ дээр багш нараа бид нар яаж бэлдэх бэлтгэл ажил ямар байгаа юм бэ, хүүхдүүдээ бид нар ямар хичээл сургуулиар оруулах гэж байгаа юм бэ? Энэний энэ алдааг нь хараад, зарим гишүүдээс өнөөдөр Хүмүүнлэг боловсролын хууль гээд бас батлагдах гээд ингээд ороод ирж байна. Ерөөсөө сүүлийн он жилүүдэд алдагдсан энэ зүйл зөвхөн мэдлэгт бид нар анхаараад, хүмүүжил төлөвшил, зан чанар бид нарын хөгжил гэдэг дээр бид нар анхаараагүй байгаа. Тэгэхээр энэ хөтөлбөр бэлэн болж байгаа юу, зөв хийгдэж байгаа юу, энэ дээр ямар ажил хийгдэж байна вэ гэдэг 4 асуултад хариулт авъя. Тэгээд шаардлагатай бол тодруулъя. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайд эхлээд хариулчихъя. Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Тэр Баярсайхан гишүүний юутай ариун цэврийн байгууламжтай холбоотой асуултад бол Ням-Очир дарга хариулаад, тэр нөгөө яг өөрийнх нь Завхан аймаг дээр байгаа 2 сургууль, дотуур байр, заалны асуудлыг хэлчихлээ. Яг тэрэн дээр одоогийн нөхцөл байдлууд дээр яг юу байна Батцэцэг дарга, Нансалмаа дарга 2 энэ дээр нэмэлт хариултууд өгчхөөрэй.

Юуны хувьд би тантай санал нэг байна. Ерөнхийдөө энэ хөдөө орон нутаг ер нь энэ төрийн тендерээр гүйцэтгэж байгаа ажлуудын чанарууд дээр бид нар нэг тодорхой ахиц дэвшил гаргахгүй бол ер нь ингээд нэг ийм тендерт ороод хийж чадна гэж хэлээд авчхаад ингээд шантаажилж, төрийг шантаажилж үүгээр мөнгө хийдэг, тендерээр бараг үндсэндээ угжны хурга шиг болчихсон ийм компаниуд зөндөө байна. Тэр тусмаа манай салбар дээр бол би түрүүн хэллээ шүү дээ 27 компанийг бид нар энэ хар жагсаалтад оруулах, хар жагсаалтад оруулж нэрийг нь зарлаж байгаа. Цаашидаа ч ер нь энэ цаашидаа энэ хариуцлагын сахилгын хариуцлагын асуудал ярихаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж байгаа. Ерөнхийдөө бид нар энэ Монгол Улсад байгаа энэ Барилгын хөгжлийн төвийн хяналт хийж байгаа асуудлууд, энэ тогтолцоогоо нэг эргэж харах авахгүй бол бас болохгүй юм байна л гэж би харж байгаа.

Одоо жишээ нь манайд гэхэд 370, 380 орчим барилгын ажлууд дээр бид нар дангаараа хяналт хийгээд, тэгээд энэ дээр чанарын баталгаануудын асуудлуудыг хийнэ гэдэг бол их хүндрэлтэй асуудал юм байна. Одоо энэ жил энэ 24 оны төсөв бол бас нэлээн томоохон төсөв орж ирж байгаа. Бараг дахиад энэ чинь нийт хэд болж байна вэ, манай салбарын хэмжээнд чинь бараг 600, 700 орчим юу болох гэж байгаа билүү тийм ээ, барилга объектууд шинээр баригдах асуудлууд гарч ирж байна. Дахиад дээрээс нь ариун цэврийн байгууламжийн 1200 орчим энэ объектууд дээр хяналт тавина гэдэг бол бас яг яам дангаараа Боловсролын ерөнхий газар дангаараа энэ нэг асуудлыг хийнэ гэдэг бол их хүндрэлтэй асуудал юм байна. Тийм учраас энэ хөрөнгө оруулалт их тавигдаж байгаа жилүүдэд магадгүй тэрэнд тохирсон, тэрний гүйцэтгэл хяналт дээр тохирсон энэ тогтолцоог уян хатан тогтолцоог бид нар нэвтрүүлэх ийм зайлшгүй шаардлага би амьдралаас үүсэж гарч байна гэж

ойлгож байгаа. Тэгээд энэ чиглэл рүү бас тантай хамтарч ажиллаж таны саналыг тусгаж ажиллаж гэж бас бодож байна.

Юуны хувьд бол энэ хүүхдийн төлөвшлийн асуудлууд мэдлэг, чадвар, төлөвшил, цогц чадамжийг эзэмшүүлэх энэ эрх зүйн зохицуулалтыг бид нар хуулиараа хийсэн. Одоо ингээд хуулийн хүрээнд бид нар хөтөлбөрийнхөө үзэл баримтлалыг боловсруулж байна Баярсайхан гишүүнээ. Тэгэхээр цаашдаа ингээд яг энэ төлөвшлийн асуудлууд дээр ямар хичээлээр тийм ээ, ямар агуулгаар, ямар арга зүйгээр, ямар орчноор, ямар боломжоор ингэж энэ төлөвшлийн хүмүүжлийн асуудал дээр ямар өөрчлөлтүүдийг хийх вэ гэдэг бол бид нар хөтөлбөрөөрөө хийгдэнэ. Тийм учраас бол удахгүй бид нар бас энэ Үндэсний зөвлөл, Боловсролын үндэсний зөвлөл Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний зөвлөл батлагдсан. Энэ Үндэсний зөвлөлөөр бид нар энэ юуныхаа хөтөлбөрийнхөө үзэл баримтлалыг батлуулж, дараа нь шинэ хуулиар бол хөтөлбөрийн үзэл баримтлал ЗГ-аар батлагддаг ийм зохицуулалттай болсон учраас ЗГ-аар батлагдсаны дараа яг ямар хичээлээр, ямар агуулгаар энэ төлөвшлийн асуудлууд, хүмүүжлийн асуудлуудыг хийгдэх вэ гэдэг асуудлуудад тодорхой болно гэж бодож байна. Ингээд нэмэлт 2 асуулт дээр Ням-Очир дарга, Батцэцэг дарга 2 хариулт өгөөрэй.

**Г.Мөнхцэцэг:** Ням-Очир дарга 4 номерын микрофон дээр хариултаа өгье.

**Т.Ням-Очир:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ариун цэврийн байгууламж ерөнхийдөө 4 ээлжээр хэрэгжээд явж байгаа, 18 аймгийн 267 сумын 853 объектыг 4 ээлжид бид нар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно гэсэн ийм эцэслэсэн жагсаалт гараад, энэ жагсаалтынхаа дагуу 4 ээлждээ объектуудаа хуваагаад ингээд ажиллаж

байна. Өнөөдрийн байдлаар бол 1, 2 дугаар ээлжийн 244 объект ашиглалтад орчихсон. 1, 2 дугаар ээлжид бол бид нар нийлээд 303 объектыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох ёстой. Энэнээс 244 объект ашиглалтад орчихсон, 23 объект дээр комисс ажиллуулахад бэлэн болгочихсон ийм байдалтай байж байгаа. Үлдсэн 4 аймгийн 12 сумын объектууд дээр бол гэрээ цуцлах, ажил эрчимжүүлэх шаардлагатай ийм ажлуудыг хийж байгаа.

2 дугаар ээлж бол ерөнхийдөө бүрэн дууссан гэж олгож болно. 2 дугаар ээлжид нь тавигдсан 135 объект дээр 14 аймгийн, 42 сумын 135 объектыг бол бид нар бүрэн дуусгаж, одоо 10 объект акт нь баталгаажчих юм бол ингээд бүр 135 объект бол ингээд бүрэн дуусаж, ашиглалтад авахаар ийм байдалтай байж байна.

3 дугаар ээлжийн зураг төслийн ажил бол 83 хувьтай. 8 аймаг дээр бол тендер зарлагдаад барилга угсралтын ажлууд бол эхэлчихсэн. Эхнээсээ ашиглалтад хүлээгээд авчихсан 3 дугаар ээлжээс бол нийт бид нар эхний 3 объектыг бол ашиглалтад хүлээгээд авчихсан. Тун удахгүй бас 10 объект комисс ажиллуулахаар ингээд мэдэгдлээ өгчихсөн ингээд байж байна. Тэгэхээр 3 дугаар ээлжийн объектууд бол тендер зарлагдаад, барилга угсралтын ажил гэсэн объектууд бол хүлээж аваад эхэлж байна. Тендер зарлагдаад явж байгаа бол 6 аймаг байна. Магадлалын дүгнэлтээ хүлээж байгаа 5 аймаг байгаа. Ингээд ер нь бол 3 дугаар ээлжийн хувьд бол магадлалын дүгнэлтүүд дуусчих юм бол энэ ондоо багтаад тендерүүд бүрэн зарлагдаад ингээд явчихна гэсэн ийм байдалтай байж байгаа.

4 дүгээр ээлжийн бол 12 аймгийн 92 сумын 243 объект байгаа. Өнөөдрийн байдлаар бол төлөвлөгдсөн зардлыг яг бодит магадлалаар батлагдсан төсөвт өртөгтэй нь харьцуулж нягтлаад зураг

төсвийн тендерүүд бол бүрэн зарлагдаад, зураг төслийн компаниуд бол ажилдаа орчихсон. Говь-Алтай, Баянхонгор гээд 2 аймаг дээр бол дахин зарлагдсан, компани дөнгөж шалгараад зураг төслийн ажилдаа ороход бэлэн болчихсон ингээд ажиллаж байгаа.

Чанартай холбоотойгоор бол бид нар ялангуяа 1, 2 дугаар ээлж дээр Эколос гээд технологийн компани бол энэ дээр бас зөвлөн тусалж ажилласан. Энэтэй холбоотойгоор ашиглалтад орсон объектууд дээр засвар үйлчилгээг хариуцах хүмүүсийг бэлтгэх, энэ хүмүүст зориулсан гарын авлагуудыг бол гаргаад ингээд явж байна. Дээрээс нь яг энэ ариун цэврийн байгууламжуудыг ашиглах чиглэлээр нэлээдгүй тийм сургалт, зөвлөгөө заавруудыг бол мэргэжлийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулж байгаа. Яг асуудал үүсэж байгаа объектууд дээр бол гүйцэтгэгч компаниудыг дахин ажиллуулах, энэ дээр нь ямар технологийн горим зөрчигдөж байгаа талууд дээр бол хяналт тавьж ажиллаж байна. Цаашилаад бас 24 оны төсөлд төсөв санхүүгийн төсөв дээр ашиглалттай холбоотой зардлуудыг суулгаж, энэтэй ашиглалтыг сайжруулах тал дээр нь бол анхаарч ажиллаж байна.

**Г.Мөнхцэцэг:** Баярсайхан гишүүн нэмж асууя. Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Өмнөх ашиглалтад орсон Завханд хийгдсэн чанаргүй барилгууд дээр яах вэ, одоо энэ яагаад гацаад байгаа юм бэ, энэ боломжтой юу гэдгийг асуусан юм. Энэ дээр тодруулга авчихъя.

2-т дараагийн асуулт бол бид нар ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт энэ бүх сургууль, цэцэрлэгийг биеийн тамирын тоног төхөөрөмжөөр хангана гээд нэг зорилттой яваад байгаа юм. Тэгээд яах вэ ковид эд нар энээ тэрээ гээд энэ хөрөнгө оруулалтууд хийгдэхгүй л

байх шиг байна л даа. Тэгээд нөгөө хүүхдийн зан чанарыг хөгжүүлэх, хүүхдийг хүчтэй эрүүл байлгахад биеийн тамирын хичээл бол маш чухал. Тэгээд энэ дээр ер нь боломж байна уу? Энэ жил нэг хагаслаад ч гэсэн орох боломж байгаа юу? Ер нь төрийн өмчит сургуулиа ярьж байна шүү дээ, төрийн өмчит ЕБС-ийг биеийн тамирын хичээлийн хэрэгслээр хангах, спортоор хичээллэх нөхцөл боломжийг нь бүрдүүлэх энэ тал дээр ямар байдалтай байна вэ?

**Г.Мөнхцэцэг:** Баярсайхан гишүүний нэмэлт асуултад Энх-Амгалан сайд нэмж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ дээр боломж байгаа гэж харж байгаа Баярсайхан гишүүнээ. Яагаад гэвэл би яагаад ингэж баттай хэлж байна вэ гэхээр энэ жил бид нар нөгөө өнгөрсөн 2 жил бид нар чинь нөхөн хангалтын зардал сургууль, цэцэрлэгүүд дээр өгдөг болсон. Тэрүүгээр зөвхөн бид нар цахим шилжилтүүдийг хий гэж хэлж байсан. Энэ жил бид нар ямар боломж гаргаж байна вэ гэхээр энэ нөхөн хангалтын зардал дээр арай ачаалал багатайгаар бид нар МЦХ, Юнител компани, Мобиком компанитай хамтарч бүх сургуулиудынхаа шилэн кабель, wi-fi, тэгээд сая бас энэ нөгөө цахим танхим байгуулах асуудлуудыг бас нэгдсэн маягаар энэ санхүүгийн түрээс хэлбэрээр 3 жилийн дотор төлбөрийг нь хуваах хэлбэрээр шийдэж байгаа учраас сургуулиуд дээр бол энэ нөхөн хангалтын эх үүсвэрүүд жаахан чөлөөлөгдөх болов уу гэж бодож байна. Тэгээд энэ жил яг энэ чөлөөлөгдөх эх үүсвэр гарч ирэхээр ерөнхийдөө тэгвэл чөлөөлөгдөж байгаа эх үүсвэрээр одоо яг биеийн тамирынхаа хичээлд шаардлагатай байгаа хэрэгслүүдийг ав гэсэн энэ чиглэлүүдийг бас өгөөд энэ дээр би боломж байгаа гэж бодож байна 1 дүгээр шийдэл. 2.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүн асуултаа асууя тийм. Тодруулга. Баярсайхан гишүүн.

**Г.Дамдинням:** Яахаар болсон бэ?

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүн түр хүлээж байгаарай. Баярсайхан гишүүний түрүүчийн тэр нөгөө Завхан аймагт 2 сургуультай холбоотойгоор асуулт асуусан тэрийг гүйцээгээд 2 номерын микрофон дээр.

**Г.Дамдинням:** Баярсайхан гишүүний хариултыг нь гүйцээгээд өгчихгүй юу даа.

**Г.Мөнхцэцэг:** 2 номерын микрофон дээр хариулах уу тийм ээ, 2 номерын микрофон дээр хариултыг өгье.

**Б.Батцэцэг:** Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Батцэцэг Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Нийтдээ 2024 оны төсвийн төсөл дээр шилжин хэрэгжиж байгаа 244 төсөл, арга хэмжээ байгаа. Өөрөөр хэлбэл гүйцэтгэл цаашид 2024 онд нийтдээ 418,3 тэрбум төгрөг. Завханы, Завхан аймгийн хүрээнд 2023 онд нийтдээ 18 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаа. Үүнээс хамгийн бага ерөнхийдөө бол бид бүхэн шилжих төсөл, арга хэмжээ рүү бол магадлалын дүгнэлт гаргуулан 2024 онд шилжих төсөл, арга хэмжээ дээрээ төсөвт өртгийн нэмэгдлүүдийг оруулж, аль болох төсвийн хөрөнгө оруулалтыг гүйцээж, барилга байгууламжийг хэрэгжүүлж бүрэн хэрэгжүүлж дуусах хүрээнд бол төсөл хэрэгжүүлэгч захиалагчийн хувьд хяналтаа тавьж, гүйцэтгэгч компаниудтай ажиллаж байгаа.

Завханы Жавхлан цогцолборын 2 дугаар байрны сургуулийн Улиастай сумын сургуулийн хувьд нийтдээ гэрээний дүн нь 4,5 тэрбум төгрөг. Өнөөдрийн байдлаар нийтдээ гүйцэтгэл 95.../минут дуусав/

**Г.Мөнхцэцэг:** Батцэцэг дарга гүйцээгээд нэг минутад хариулчихъя.

**Б.Батцэцэг:** Завханы Жавхлан цогцолборын хувьд бол боломжтой. Эрдэнэхайрхан сум дээр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хувьд бол боломжгүй. Түрүүн сайд хэлж байсан нийтдээ 123 төсөл, арга хэмжээ дээр магадлалын дүгнэлт гаргаад, Үндэсний аудитын газраас 2024 оны төсвийн төсөлд оруулсан байгаа. Тэгэхээр магадлал хийх боломжгүй нийт 43 төсөл, арга хэмжээний бас нэг нь байгаа. Тэгэхээр цаашид бид бүхэн ер нь бол гүйцэтгэгч компани хангалтгүй байгаа тохиолдолд бид нар 1 дүгээрт гэрээг цуцалж байгаа. Гэрээг дүгнээд, цаашид шинэ шинээр хэрэгжүүлэх энэ төсөл, арга хэмжээнийхээ гүйцэтгэлийг хангах хүрээнд бол холбогдох арга хэмжээнүүдийг аваад явж байгаа. Яамны зүгээс бас энэ дээр бас анхаарч бичиг хүргүүлэх, мөн дээрээс нь хар жагсаалтад бас бид бүхэн Сангийн яамтайгаа хамтарч бүртгээд ингээд явж байгаа.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүн асуултаа асууя.

**Г.Дамдинням:** Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээний хөрөнгө оруулалттай холбоотой мэдээллийг бид нар сонслоо. Тэгээд өнгөрсөн хаврын чуулганаар бид нар Боловсролын ерөнхий хууль болон хамт өргөн мэдүүлсэн багц 4 хууль батлаад гаргачихсан. Тэгээд хуулийн хэрэгжилттэй холбоотой бас нэг асуулт байна. Бид нар ер нь бол нэлээн л чамбай сайн хууль нэлээн удаан хугацаанд ярьж байгаад батлаад гаргачихсан. Тэгээд ямар ч хуулийн шинэчлэл төсвийн дэмжлэг өөрөөр хэлбэл тэр хууль дээр туссан зүйл заалтууд нь санхүүгийнхээ хувьд хэрэгжээд явдаг байж байж л хэрэгжинэ. Тэгээд би Монгол Улсын ЗГ-аас өргөн барьсан төсвийн төслийг үзлээ. Тэгээд төсвийн төсөл дээр



боловсролын салбар дээр нэг тодорхой 2 асуулт байгаа юм. 1 дүгээрт энэ Боловсролын ерөнхий хуулиар заагаад өгчихсөн байгаа их дээд сургуулиудын тогтмол зардлыг төр хариуцна гэдэг заалт яагаад хэрэгжээгүй байна вэ? Төсвийн төсөл дээр ямар ч мөнгө тавигдаагүй байна.

Өөрөөр хэлбэл боловсролын шинэчлэлийн хүрээнд бид нар их дээд сургуулиудыг санхүүгийнх нь хувьд бол бие даалгана. 2 дугаарт төрөөс тодорхой хэмжээний бодит дэмжлэгийг үзүүлнэ. Эхний ээлжид энэний эхний дэмжлэг нь бол үндсэндээ тогтмол зардал байж. Өөрөөр хэлбэл энэ 8-аас 10 хувь байдаг юм л даа их дээд сургуульд би өөрөө ажиллаж байсан, мэдэж байна. Тэгэхээр энэ хэмжээний эх үүсвэр энэ их дээд сургуулиудад очих ёстой байсан энэ 1 дүгээрт алга байна. Энэ хуулиа яаж хэрэгжүүлэх юм бэ, энэ их сургуулиуд чинь энийг зөвшөөрч байгаа юм уу, харсан юм уу? Энэ байхгүй бол цалин нэмэгдлээ энэ хүмүүс чинь хийж чадах юм уу? Их сургуулиуд чинь амьд үлдэж чадах юм уу, санхүү нь хүрэх юм уу? Тэгээд төсөв дээр та нар яаж оруулж ирж байгаа юм бэ энийг?

2 дугаарт энэ боловсролын тэгш бус байдлыг арилгах 2 дахь том чиглэл бол юу юм байгаа юм энэ дижитал боловсрол. Өөрөөр хэлбэл онлайн боловсрол. Энэ шинэжлэх ухаан технологийн шинэ дэвшлийг ашиглаж хэрэгжүүлэх энэ үйл явц юм байгаа юм. Тэгэхээр энэ дижитал боловсролыг улс орон даяар дэмжиж, санхүүжүүлж байж бид нар боловсролын тэгш бус байдлыг арилгана. Боловсролын тэгш бус байдлыг арилгаснаар нийгмийн тэгш бус байдлыг арилгана л гэж зорьж байгаа шүү дээ. Тэгэхгүй бол бид нар 20, 30 мянган багшийг нэгэн дор бэлдээд, тэд нар нь нэг стандартаар хичээл заагаад явах хугацааг хүлээнэ гэвэл мөдгүй.

Харин Улаанбаатар хотын 1 дүгээр сургуульд байгаа математикийн

багш эсвэл 11 дүгээр сургуульд байгаа физикийн багш ч гэдэг юм уу эсвэл Хөвсгөл аймагт байгаа математикийн багш, Дархан-Уул аймагт байгаа англи хэлний багш ч гэдэг юм уу улсын хамгийн шилдэг багш нар онлайн-аар хичээлээ тавиад тэрийг нь үзэх боломжийг хангахад санхүүжилт хэрэгтэй байхгүй юу. Тэгэхээр улсын төсвийн төсөл дээр ЗГ-аас өргөн мэдүүлсэн төсөл дээр энэ дижитал боловсролд тавигдсан төсөл мөнгө чинь хүрэх юм уу? Байхгүй л харагдана лээ дээ. Энэ 2 асуултад хариулаадхаач.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариульж.

**Л.Энх-Амгалан:** Дамдинням гишүүнээ юу яг энэ жилийн бид нарын энэ Улсын Их Хуралд өргөн бариад байгаа Улсын төсвийн тухай хуулиар бол манай салбарын урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардал бол бараг 1,1 их наядоор нэмэгдэж, 4,4 их наяд болж байгаа. Энэ дээр бол шинэ хуулийн хэрэгжилтийг хангах чиглэл рүү бол бид нар нөгөө хөдөө орон нутагт ажиллаж байгаа багш нар дан ганц багш нар биш, ер нь боловсролын байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн нөгөө 5 жилд авдаг байсан 6 сарын нэмэгдлийг 3 жил тутам авдаг болгож энэ шинэ зохицуулалт хийсэн учраас энэтэй уялдуулж бараг далаад тэрбум төгрөгийн санхүүжилт. Ингээд нөгөө багшийн хүүхэд их дээд сургууль, төрийн өмчийн их дээд сургуульд тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр сурвал сургалтын төлбөрийг нь төр заадаг болсон учраас энэтэй уялдуулж 7,6 тэрбум төгрөгийн санхүүжилт гээд ингээд яг шинэ хуулийн төсөлтэй, шинэ хуулийн заалтуудтай хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зуугаад тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэрүүд бас суусан байгаа.

Яах вэ ер нь их дээд сургуулиудын энэ юу бол тогтмол зардлыг санхүүжүүлэх энэ хууль бол байгаа.

Гэхдээ энэ дээр бол хуулийн дагуу бас хэрэгжүүлэх энэ журам батлагдаж амжаагүй байсан учраас яг Их Хурал дээр өргөн барихад энэ журмууд баригдаж юу батлагдаж амжаагүй байсан учраас бол энэ дээр нэг жаахан гайн үүссэн тохиолдол бий. Гэхдээ одоо яг энэ хуулийн хэлэлцүүлгийн үед Их Хурал дээр гарч байгаа хуулийн хэлэлцүүлгийн үед бол тодорхой урсгал зардлын зохицуулалтууд хийгдэж, энэ 14,3 тэрбум төгрөг шаардлагатай байгаад байгаа тийм ээ. Тэгэхээр энэний эх үүсвэрүүдийг гаргах чиглэл рүү бас ажлын хэсгийн түвшинд бол ажиллахад тодорхой орон зай гарах болов уу гэсэн ийм хүлээлттэй байна 1 дүгээрт нь.

2 дугаар асуудал бол энэ цахим шилжилтийн асуудал, энд шаардлагатай байгаа санхүүжилтийн асуудлууд, та нарт ер нь мөнгө төгрөг чинь хүрэх юм уу гэж асууж байх шиг байна. Цахим шилжилт бол ер нь хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгах хамгийн бидэнд олдож байгаа хамгийн том боломж бол би цахим шилжилт гэж харж байгаа. Тантай санал нэг байна. Тэгэхдээ бид нар цаашидаа ер нь энэ боловсролын салбарынхаа санхүүжилтийн эх үүсвэрийг нэг олон эх үүсвэрт болгох энэ эрх зүйн боломжуудыг бид нар ер нь гаргаж ирэх ёстой юм байна. Дан ганц төсвөөрөө урсгал зардлаа, хөрөнгө оруулалтынхаа зардлыг шийдвэрлээд явахад бол их хүндрэлтэй асуудал.

Одоо хэдийгээр бид нар ДНБ-ийхээ 4,6 хувийг санхүүжүүлж байгаа ч гэсэн бусад улс оронтой харьцуулахад манай боловсролд зарж байгаа мөнгө төсвөөс уян ДНБ-тэй харьцуулахад бол 8-аас 12 дахин бага мөнгө зарж байгаа шүү дээ бид нар. Тэгэхээр одоо өөр эх үүсвэр буюу энэ баялгийн сангийн эрх зүйн зохицуулалт байх юм бол энэний тодорхой эх үүсвэр байдаг юм уу эсхүл тодорхой хүн амын орлогын албан татварын тодорхой хувь 1-ээс 2 хувийг

боловсролд зарцуулдаг бусад улсуудын ийм туршиллагууд байна. Тэгэхээр өөр эх үүсвэрүүдийг гаргаж ирж байж бид нар энэ боловсролд үүсээж байгаа санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлууд, хэрэгцээний асуудлуудаа шийдвэрлэх ийм л шийдэл байна л гэж би харж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бол энэ жил ямар ч байсан бид нар багш нараа 100 хувь компьютержуулна, *notebook*-жүүлнэ. Энэ бол тодорхой эх үүсвэрээр ингээд шийдэгдээд явчихна.

Ер нь бол энэ боловсролын тэгш хүртээмж, чанарыг дээшлүүлэх чиглэл рүү бол цахимжуулна шүү дээ. Одоо бид нарын хийж байгаа энэ цахим сургууль Мэдлээ сургууль бол маш том боломж гаргаж байгаа. Энэ бол яг таны түрүүн хэлж байгаа Монголын хамгийн сайн багш нараар хүүхэд хаана амьдарч байна, хаана сурч байгаагаас үл шалтгаалж ингээд чанартай, сонирхолтой хичээл үзэх энэ боломжуудаар бид нар хангаж эхэлсэн. 10 дугаар анги, энэ жил 11 дүгээр ангийг авч байгаа. Тэгээд цаашидаа бол бид нар энэ боловсролын салбарт хэрэгжүүлж байгаа багшийн ур чадвараас үл шалтгаалсан англи хэлний *pearson* хөтөлбөр, Финляндын математикийн *eduten* хөтөлбөрүүдийг улс орон даяар бас хэрэгжүүлж байгаа сайн туршиллагууд байна. Тэгээд энэ чиглэл рүү бид нар шаардлагатай байгаа санхүүжилтийг, нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардлынхаа бүтэц аргачлалыг өөрчилж байж энэ эх, санхүүжилтийн эх үүсвэрийг гаргах ийм боломж орон зайнууд нь байгаа болов уу л гэж харж байгаа.

**Г.Мөнхцэцэг:** Дамдинням гишүүн нэмж, Дамдинням гишүүн асуултаа асууя.

**Г.Дамдинням:** Энх-Амгалан сайдаа яах вэ бас төсөв нэмэгдэж байгаа, тэгээд төсөв нэмэгдэх бол өөрөө шалтгаантай учраас нэмэгдэх ёстой юм нэмэгдэх л ёстой. Тэгээд бусад юм нь

нэмэгдэж байгаа гээд энэ бол бид нар нэмж чадаагүй гээд зогсож байх бол тийм сайн зүйл биш. Яах вэ мэдээж таныг бол ойлгож байна. Сангийн яамтайгаа хэл үгээ олох талаас нь л ярьж дуугарч байх шиг байна. Их дээд сургуулийн чинь хэдэн мянган багш, удирдлага ажилтан, албан хаагчид хараад сууж байгаа юм байна лээ шүү. Тэр их дээд сургуулиудынхаа тогтмол зардлыг энэ төсвийн хэлэлцүүлгийн үеэр бас ярилцаж оруулах талаас нь анхаармаар, анхаараарай.

2 дугаарт энэ дижитал хэрэглээний зардлыг өсгөх тал дээр бас энэ төсвийн үеэр анхаараарай л гэж хүсье дээ. Тийм. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Баярлалаа. Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор надад бас 2, 3 зүйлийн асуулт байна. Нэг бүрчлэн хариулаарай гэж. Ингээд сайдын танилцуулгад бол яах вэ ер нь ингээд 24 он гэхэд бид нар Монгол Улсын ЗГ-аас гаргасан энэ 273 сургуулийг барина, 200 цэцэрлэгийг байгуулна гээд ингээд хөтөлбөр нь бол үндсэндээ бол 100 хувь 24 он гэхэд бол бид нар биелж байгаа гээд ингээд танилцуулга хийчих шиг боллоо. Тэгээд Байнгын хороон дээр бол тусгайлаад бас ингээд сургуулиуд, бас харьяа дүүргүүд, орон нутгаас гээд ингээд олон гомдол асуултууд бас ирдэг. Албан бичгээр бас олон саналуудыг бас тавьдаг. Тэдний нэг нь бол яалт ч үгүй энэ Монгол тэмүүлэл 133 дугаар сургууль дээр бид нар намар очиж ажиллаж байсан. Энэ сургуулийн намар гэхэд бид нар ашиглалтад оруулна гээд ингээд ярьж хэлж явсан. Тэгээд энэ асуудал ямар хааш нь шийдэгдсэн бэ? Өнөөдөр ашиглалтад оруулаагүй ингээд байж байгаа. Энэ байдал дээр хаанаасаа ямар анхаарал тавьж ингээж ажиллаж байгаа вэ, энэ сургуулийн барилга юу болсон бэ?

5 дугаар сургуулийн асуудлыг бас удаа дараа Байнгын хороон дээр энэ гомдол чирэгдэл ирж байгаа. Энэ

сургуулийн төсөвтэй холбоотой асуудлууд хэрхэн шийдэгдэж байгаа вэ 2.

3 дугаарт энэ БЗД-ийн 21 дүгээр сургууль гээд энэ сургууль үндсэндээ 76 сурагчаас анги дүүргэлт 50 орчим хувьтай явж байгаа гэж байгаа юм. Тэгээд сургуулийн байр хүрэлцэхгүй байгаа учраас үндсэндээ тэр Эко Ази гээд сургуулийн байрыг сарын 26 сая төгрөгөөр түрээстэйгээр хичээллэж байна гэсэн ийм гомдлууд ирж байгаа. Энэ нийслэлд байж байгаа энэ 3 сургуультай холбоотой асуудлууд ойрын үед ирсэн учраас энэний асуудлуудыг яаж шийдэж байгаа вэ? Хөдөө орон нутагт бол мэдээж олон барилга байгууламжтай бол холбоотойгоор асуудлууд ирдэг. Эхний ээлжид энэ 3 сургуулийн барилга байгууламжийн асуудлууд ямар хэлбэртэйгээр байгаа вэ? Энэ дээр хариулт авъя гэж. Энх-Амгалан сайд саяын асуултад хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ БЗД-ийн 26 дугаар хороонд байгуулагдаж байгаа та өнгөрсөн хавар бас очиж Байнгын хорооны даргын хувьд очиж ажилласан энэ сургууль байгаа. Тэгээд энэ сургууль нөгөө дэд бүтцийн асуудлууд нь шийдвэрлэгдэж чадаагүй байгаа. Цаад талдаа дулааны шугамын асуудлууд үүссэн учраас бараг үндсэндээ 6 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт хэрэгтэй болсон учраас бид нар энэ нийслэлтэй ярьж байгаад энэний эх үүсвэрийг ноднин цэцэрлэгийн хүртээмжийн хүрээнд шийдвэрлэж, одоо энэ жил ажлууд нь дууссан. Одоо ингээд Монгол тэмүүлэл сургууль маань нүүгээд орчихсон тийм ээ, нүүгээд орчихсон үйл ажиллагаанууд нь эхэлж байгаа. Энэ дээр бол ямар нэгэн асуудал байхгүй болов уу гэж бодож байна. Энэ чинь 3, 2 сургууль, 1 цэцэрлэгийн асуудал байгаа юм. Тэгээд энэ та бол бас газар дээр нь очиж ажиллаж, танилцаж болно. Ингээд энэ асуудлууд бүрэн шийдвэрлэсэн. Гэхдээ энэ бол бид нар бас нэлээн энэ зунжингаа миний бие бол очиж бараг 2, 3 удаа очиж ажилласан

учраас ерөнхийдөө хот, яам олон талын хамтын ажиллагааны хүрээнд бол энэ асуудлууд бас шийдвэрлэгдсэн гэдгийг бас хэлье гэж бодож байна.

5 дугаар сургуулийн хувьд энэ ЧД-ийн 5 дугаар сургуулийн хувьд бол бид нар гэрээг нь цуцлах ийм юу өгч байгаа тийм. Яагаад тэгж байна вэ гэхээр ер нь ганцхан 5 дугаар сургууль ч биш, энэ 90-ээс 95 хувийн дээш гүйцэтгэл гаргачхаад 2, 3 жил ингээд сургуулиа цоожлоод орхиод хаячихдаг ийм компаниуд, даварчихсан компани гэж хэлэх юм уу тэгээд ийм компаниудын асуудлууд байна. Тэгээд маш их олон тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтүүд нэхдэг. Яг энэ асуудал бол 5 дугаар, одоо энэ 5 дугаар сургууль чинь бараг үндсэндээ 95 хувийн гүйцэтгэл гарчихсан сургууль байхгүй юу. Одоо нэг жаахан жижигхэн косметик засал хийгээд, тэр нь бол нэг 600, 700 сая төгрөгийн асуудал байхад бол засвар хийгээд орчих ийм боломж байна. Тэгэхэд компани нь 4, 5 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт нэхээд ийм байдалд байж болохгүй. Тийм учраас хөндлөнгийн бид нар мэргэжлийн экспертийн компани ажиллуулсан, Барилгын хөгжлийн төвийнхөн бас магадлалаа хийгээд энэ чинь 300, 400 сая төгрөгийн л асуудал байхад компани нь ингэж илүү их мөнгө нэхдэг ийм асуудлууд үүссэн учраас энийг гэрээг нь цуцална гэдэг асуудал байгаа. Тэгээд гэрээг нь цуцалснаар бид нар нэмж магадлан хийгээд энэ сургуулиудыг үйл ажиллагааг нь жигдрүүлэх чиглэл рүү бид нар яачих болов уу гэж бодож байна.

Одоо энэ 3 ээлжид орчихсон байгаа сургуулиуд дээр энэ намар бид нар сургууль барьж амжихгүй. Энэ шинэ сургууль барьсан ч гэсэн ерөнхийдөө ирэх намар ч гэсэн орох эрсдэлтэй байгаа учраас зарим сургуулиуд дээр үнэхээр түрээсийн байрыг, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулахаас өөр бид нарт сонголт байхгүй. Одоо ямар сургуулийг нь тарааж, хүүхдүүдийг гэртээ бай гэж хэлэлтэй биш. Энэ бол дундын шийдэл,

дундын шийдэл. Тийм учраас бид нар энэ нийслэл дээр нэлээн судалгаанууд хийгдэж, 1 дүгээрт өөрийн газартай сургуулиуд хэд байна, 2 дугаарт яг одоогийн байгаа барилга байгууламжуудыг нь өргөтгөх бололцоотой сургуулиуд хэд байна вэ гэдэг ийм судалгаануудыг бас бид нар хийсэн байгаа. Энэ дээр 17 сургууль байхаа Ням-Очир даргаа би андуураагүй бол 17 сургуулиуд дээр өөрийн газартаа өргөтгөл хийх бололцоотой сургуулиуд дээр бид нар бас 24 оны төсөв, цаашидаа хотын батлагдаж байгаа төсөв дээр, мөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн санхүүжилтийн эх үүсвэрүүдээрээ энэ асуудлуудыг шийдвэрлэе л гэж бодож байгаа.

Үнэхээр яг үндсэндээ Монгол Улс тэр чигээрээ нэг ангийн хүүхдүүд нь 45-аас 50 хүүхэд, 60 хүүхэд сурчихсан, сурч байгаа ийм асуудал бол бас байхгүй шүү дээ. Нийгэмд энэ фэйсбүүкээр нэг ганц нэг сургуулиуд дээр гарч байгаа асуудлуудыг ингээд тэр чигээрээ ер нь Монголын боловсролын салбар тэр чигээрээ 3 ээлжид орчихсон, тэр чигээрээ нэг ангид 50-аас 60 хүүхэд сурч байгаа ийм боловсролын системд бид нар шилжүүлээгүй шүү. Энийг би бүүр хатуу юутай илэрхийлье гэж бодож байна, байр суурийг илэрхийлье гэж бодож байна. Энэ дээр яг Монгол Улсад байгаа сургуулиуд, Монгол Улсад байгаа бүлэг ангиудын дүүргэлтүүд дээр бид нар ажиллаж байгаа учраас энэ дээр нэг цөөн хэдэн 17 хүрэхгүй сургуулиуд дээр л ийм асуудал үүсэж байгаа. Энийг бид нар дунд болон урт хугацааны шийдлүүд гаргаж байж, энэ эрсдэлүүдээс гарах ийм л бодлогын шинж чанартай арга хэмжээ байгаа юм шүү гэдгийг бас би онцолж хэлье гэж бодож байгаа юм.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдад баярлалаа. Сайдын мэдээлэлтэй холбоотойгоор асуулт асууж, хариулт авлаа. Сайдын мэдээлэлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Ингээд өнөөдрийн манай



*Байнгын хорооны хуралдаан үүгээр өндөрлөж байна. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд, ажлын хэсгийнхэндээ бас баярлалаа.*

*Хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.*

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА*